In 2004, the UNESCO World Heritage Committee inscribed Orkhon Valley Cultural Landscape on World Heritage List, including valuable historical and cultural heritages of human history. Orkhon Valley Cultural Landscape has over 100 cultural sites and about 1350 historical and cultural immovable properties, covering area of 121,967 hectares. Orkhon Valley Cultural Landscape has number of immovable properties selected to state and provincial protection.

“The Law for Protection of Historical and Cultural Properties of 1994” has been revised and changed to “the Law for Protection of Cultural Heritage” by the State Great Khural in 2001. As a result of the past 10 years archeological excavations and research works, the number of cultural properties were discovered, and further protection was required for the preservation of those properties. In accordance with it, the “List for Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province” was revised by the government in 2008. On May 14th of 2008, the protection list has been revised by the 175th resolution of Government, and 175 immovable properties were selected as the state protection, 275 immovable properties are under province protection. 15 immovable properties are included in the state protection. 40 immovable properties are under the state protection, 57 immovable properties under province protection. And for the first time, paleontological sites were selected in the protection list of the state

and province.

Protection zone of immovable properties: In Paragraph 6 of article 16, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994”, “Government has set up 0.1-3 kilometers of protection zone around the historical and cultural immovable properties, such as remains of ancient cities and settlements, buildings, architecture complexes in order to provide the integrity and safety thereof”. In accordance with this article, setting up protection zones around the immovable properties oversaw their significance on history, culture, science and classification on state protection. By the 241st resolution of Government in 1997, first protection zone was set up around ruins of Kharkhorum city, capital of Mongolian Empire, covering an area of 9.69 square kilometers.

The “Protection law of Historical and Cultural Properties of 1994” revised and changed to “Protection law of Cultural Heritage” by the State Great Khural, in 2001. Paragraphs 6, 7, 8 of article 17, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994” re-entered into “Protection Law of Cultural Heritage” and the article for measurement of surrounding areas was removed

- By the 96th decision of 2001, the protection zones were set up around the Gandantegchinlen Khiid monastery, Monastery Geser, Green Palace of Bogd Khaan, Temple of Choijin Lama, Temple of Dambadarjaa, Temple of Dashchoilon (Wooden temples), Apartment of Chin Van Khanddorj.
- By the 71st decision of 2002, protection zones were set up around the inscribed monuments for Bilge Khan, memorial complex of Kültegin in Khashaat soum of Arkhangai province, ruins of Khar Balgas in Khotont soum of Arkhangai province, Tövkhön Monastery in Bat- Ölziiit soum of Öwörkhongai province, inscriptions monument of Tonyokuk in Bayan soum of Töv province.
- By the 190th decision of 2003, the protection zones were set up around the complex of deer stone called place of Uushgiin Öwör in Burentogtokh soum of Khövsgul province, ruins of Avarga in Delgerkhaan soum of Khentii province, temple of Manzushir in Töv province, 2 stone columns of monastery Dari-Ekh in Baynzürkh district of Ulaanbaatar city.
- By the 126th decision of 2004, the protection zones were set up around the ruins of Baruun Khüree in Kharkhorin soum of Öwörkhongai province, remains of 2 temples of Khögnö Tami in Rashaant soum of Bulgan province
- By the 70th decision of 2006, protection zones were set up around the inscriptions monument and building remains of Tsogtiin Tsagaan baishin, ruins of Khar Bukh in Dashinchilen soum of Bulgan province
- By the 123rd decision of 2006, the protection zones were set up around the Orkhon Valley Cultural Landscape as inscribed on World Heritage List, in Arkhangai, Öwörkhongai, Bulgan province
- By the 135th decision of 2009, the protection zones were set up around the paleontological sites of Ergeliin Zoon in Khatanbulag soum Dornogobi province, complex monuments of Öngöt in Altanbulag soum Töv aimag, complex monuments of Ikh Khöshööt in Delgerkhaan soum Khentii province, complex monuments Öglögchiin Kherem, Rashaan Khad, Üzüür Tsohio in Batshireet soum of Khentii province, Baldan Bereeven temple and rock paintings in Ömnödelger soum of Khentii province, complex monuments of Dund Jargalant, complex of Tsetsen Khan palaces in Kherlen soum of Khentii province, historic building called “Öndör Khorshoo” (recent Fine Art Museum) in Chingeltei District of city Ulaanbaatar, historical building of Central Committee of People’s Party and People’s Government (recent Museum of the History of Ulaanbaatar)
- By the 101st decision of 2011, the protection zone was set up around the monastery Amar bayasgalant in Baruunbüren soum of Selenge province
- By the ... decision of 2011, the protection zone was set up around the Shoroon Bumbagar of Ulaan kherem in Bayannuur soum of Bulgan province
- By the 104th decision of 2012, protection zones were set up around the Sujigtiin am in mountain Noyon in Bornuur soum of Töv province, Zuramt and Juramtyn am in mountain Noyon in Batsumber soum, complex site of Khünnü noble (Xiongnu) in Balgasan tal in Öndör-Ulaan soum of Arkhangai province

Current status and implementation of works of the protection of historical and cultural immovable properties: Many of our historical and cultural immovable properties have already been destroyed by the human activities and natural and weather decays.

Stone monuments are damaged, cracked, disintegrated by water, wind, chemical substances and bacterial damages, which penetrates pores and capillaries of stone. And natural disaster as a quake, fire, water flood, snow and dust

storm has damaged stone monuments. Most of the all immovable properties in Mongolia have damaged by water and component became more porous.

Social factors, such as disrespect to culture, urbanization, economic crisis, sparse population, industrialization, illogical policy, irrational planning, religious issues, wrong conservation and protection, human improper activities are damaging historical and cultural heritages.

Recently, physical damages of immovable properties have increased substantially, due to people's worship ceremonies. When people worship, they offer and spray milk, butter oil on stones, and wrap them with silk scarf, which have resulted in destruction of these stone monuments.

Today, social behavior has developed disrespect for historical and cultural heritage, people are making illegal excavations to find profits, that also causes destruction and damage for the immovable properties. Also writing letters or drawing images and symbols on ancient rock inscriptions and rock paintings take place.

Since 1940, Mongolia has been organizing number of research and conservation works on protection of immovable properties. In 1944, monastery Erdene Zuu and temple Amarbaysgalant were conserved and restored. In 1960-1961, temple of Choijin Lama, Green Palace of Bogd Khaan were conserved and restored as well.

In 1971, the "Agency of Academy for Research and Scheme Planning of Historical and Cultural Property" was established in the Central Architectural Institute. In 1973, the "Restoration Laboratory of Historical and Cultural Property" was established under the Ministry of Culture. In 1976, both organizations had united under the name of "Conservation and Restoration Laboratory of Historical and Cultural Property". Since that time until 1995, the organization have conserved many architectural buildings, such as Erdene Zuu, Amarbaysgalant, Gandantegchinlen, Green Palace of Bogd Khaan, temple of Choijin Lama, complex of Tsetsen Khan palaces, monastery of Khachin Lama, apartment of Chin Van Khanddorj, historic buildings in Altanbulag relevant to the People's Revolution etc. Also local administrations have built fences, put introduction boards near the immovable properties for protecting them.

Through 1999-2005, the "National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties" was implemented, organizing a systematic conservation and preservations of historical and cultural immovable properties.

Within the framework of this project, Center of Cultural heritage and its conservators and specialists have conserved and preserved immovable properties, made copies and replicas of properties for the storage in the state fund, which are of significant historical and scientific value to Mongolians. And in the framework of this project, number of works have been implemented, such as building fences, conserving monastery and temple buildings, setting up lightening arresters etc.

In 2007, the "National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties" adopted by the 303rd decision of government, for promoting the immovable properties combined with the infrastructure and tourism, and to build capacity of conservators on cultural heritage conservation. The project is planned to be implemented from 2008 till 2015. The work has started. .

Mongolian government is implementing number of works on protection of historical and cultural immovable properties, but it was being destroyed and damaged by the improper activities of people. To stop and prevent this illegal activities on historical and cultural immovable properties, the support of local people is essential.

In the end, we should always remember that our main priority and responsibility is to respect and protect our historical and cultural heritage and pass it on to the future generations.

АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДҮРСГАЛЫН ТУХАЙ

Архангай аймгийн товч танилцуулга. Архангай аймаг нь Монгол улсын төв хэсэгт, хойд талаараа Хөвсгөл, Азүүн талаараа Булган, өмнө талаараа Өвөрхангай, Баянхонгор, баруун талаараа Завхан аймагтай тус тус хиллэн 55.3 мян.км² газар нутаг эзлэн оршдог. Аймгийн төв Цэцэрлэг хот, Улаанбаатараас 477 км зайд оршино.

Архангай аймгийн газар нутаг нь Ардын хувьсгалаас өмнө Сайн ноён хан аймагт, 1923 оноос Цэцэрлэг Мандал уулын аймагт тус тус харьяалагдаж байжээ.

БНМАУ-ын Бага хурлын 1931 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 5 дугаар хурлын тогтоолоор 5 аймгийг 13 аймаг болгон зохион байгуулсны нэгээр Архангай аймгийг 35 сум, 22285 өрх, 65333 хүн амтай, 1800000 малтайгаар байгуулсан байна.

Өнөөдөр Архангай аймаг Батцэнгэл, Булган, Жаргалант, Ихтамир, Өгийнуур, Өлзийт, Өндөр-Улаан, Тариат, Төвшрүүлэх, Хайрхан, Хангай, Хашаат, Хотонт, Цахир, Цэнхэр, Цэцэрлэг, Чулуут, Эрдэнэбулган, Эрдэнэмандал гэсэн засаг захиргааны 19 сум, 99 багтай. Тус аймагт нийт 91.000 хүн оршин суудагас 90.98 хувь нь халх бөгөөд Өлзийт, Хотонт, Өгийнуур сумдад Өгөлд ястнууд амьдардаг.

Аймгийн нутаг дэвсгэрийн ихэнх нь ойт хээр, тал хээрийн бүсэд багтдаг бөгөөд баруун урдуур нь Хангайн нуруу, баруун хойгуур нь түүний салбар болох Тарвагатайн нуруу оршдог ба зүүн болон төв хэсгээр тэдгээрээс эх авсан Орхон, Хануй, Тамир, Чулуут зэрэг томоохон голууд урсдаг. Хамгийн өндөр цэг нь Хангайн нурууны Харлагтайн сарьдаг 3539 м ба хамгийн нам цэг нь Орхон-Тамирын бэлчир 1290 м болно. Мөн Суварга хайрхан уул, Унтаа уул, Ямаат уул, Ноён хангай уул, Хан Өндөр уул зэрэг сүрлэг уулстай. Цэнхэр, Хадат, Бор тал, Цагаан сүм, Мухар Хужирт, Бэлх зэрэг халуун, хүйтэн рашаан олонтой.

Архангай аймгийн газар нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвлийн дундаж температур 1-р сард -15.6 хэм хүйтэн, зун нь 7-р сард +14.7 хэм дулаан байдаг. Хангайн нуруу нь манай орны хамгийн их тунадастай нутгийн нэг бөгөөд Цэцэрлэг хотод жилд дунджаар 344 мм тунадас унана. Салхины дундаж хурд нь 2.6 м/с бөгөөд хамгийн их салхитай байдаг 4-р сарын дундаж хурд нь 3.5 м/с юм.

Архангай аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэж судалсан тухай. 1889 онд Оросын Газарзүйн Нийгэмлэгийн Дорнод Сибирийн Салбарын Н.М.Ядринцев Монгол нутгаар аялах зуур тухайн үеийн Сайн ноён хан аймгийн Очирбат Түшээт ханы хошуу буюу одоогийн Архангай аймгийн Хашаат сумын нутаг Орхон голын хөндий Хөшөө Цайдамаас өмнө нь “Енисейн бичээс” хэмээн шинжлэх ухаанд нэрлэгдсэн үл мэдэгдэх бичигтэй хэд хэдэн том хөшөө олж илрүүлэн хэвлэн нийтэлснээр Монгол оронд археологийн судалгаа эхлүүлсэн хэмээн судлаачид үздэг нь Архангай аймгийн нутгаас эхлэлтэй аж.

Н.М.Ядринцевын мэдээлсэн мөрөөр 1890 онд Финляндын эрдэмтэн Г.Гейкелээр удирдуулсан шинжилгээний анги Монголд ирж ажиллахдаа Хөшөө Цайдамын цогцолбор дахь руни бичээст гэрэлт хөшөөнд судалгаа хийжээ. Үүний дараа жил 1891 онд Оросын ШУА-аас академич В.В.Радловын толгойлсон шинжилгээний анги Хөшөө Цайдамд хийсэн үндсэн ажлын зэрэгцээ тус шинжилгээний ангийн салбар хэсгүүд олон тооны эртний дурсгалууд илрүүлж олсноос Архангай аймгийн нутаг Өгий нуурын орчимд толгойгүй нэгэн хүн чулуу бүхий тахилын чулуун хашлага, Хануй голын хөвөөн дэх эртний хотын туурийн ойролцоо байх мөн толгойгүй 2 хүн чулуу хүн зэргийг илрүүлэн мэдээлсэн байдаг. Мөн энэ шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан Д.А.Клеменц Ихтамир сумын нутагт орших Тайхар чулуунаа бичиж үлдээсэн руни бичгийг хуулан авсныг В.В.Радлов тайлан уншсан аж. Энэхүү руни бичиг нь Төв Азиас бэхээр бичиж үлдээсэн цорын ганц дурсгал гэдгээрээ онцлогтой юм. Үүнээс хойш Тайхар чулуун дээр байх руни, согд, уйгур, монгол, дөрвөлжин, төвд, ланз, манж, тод, нангиад зэрэг арав гаруй зүйл үсэг бичгийн 200 орчим дурсгал байдгийг Х.Н.Орхун, С.Е.Малов, Х.Пэрлээ, Б.Ринчин, С.Харжаубай, О.Ф.Серткаая, Ц.Баттулга, Б.Азаяа нар судалгаа хийж хэвлэн нийтлүүлсэн байна.

Г.Гейкел, В.В.Радлов нар Хөшөө Цайдамаас хуулж авсан үл мэдэгдэх бичээсийг 1892 онд Хельсингфорс, Петербург хотод тус тус нэгэн зэрэг хэвлэн нийтлүүлсэн бөгөөд бичээсийг 1893 онд Л.П.Томсон тайлан уншиж 38 үсэг бүхий бичиг болохыг тогтоожээ. Мөн түүний зэрэгцээ 1894 онд В.В. Радлов дээрхи бичээсний 38 үсгийн 15-ыг бие даан уншиж эртний Түрэг улсын Билгэ хаан өөрийн дүү Күл Тегинд зориулан босгосон хөшөө хэмээн уншиж тайлжээ.

1906-1909 онд Монгол орны төв болоод баруун хойд нутгуудаар аялан явж судалгааны ажил хийсэн Финландийн эрдэмтэн И.Г.Гранэ Урд Тамирын голын орчим дахь Тоглохын тал хэмээх газарт буй хүн чулуу, чулуун хонь, хашлага бүхий тахилгын онгоныг тодорхойлж гэрэл зурагтай нь нийтлүүлжээ.

1910-аад оны үед Польшийн эрдэмтэн В.Л.Котвич бичсэн нэгэн өгүүлэлдээ Хөшөө Цайдам дахь Күл Тегиний тахилын онгоны цогцолборыг үзэж, уг дурсгалын хэлбэр төрх, анх олдсон хэвээр байгааг дурдсанаас гадна, Хүрээнд сууж байсан манж амбан Сандогийн зарлигаар уг бичигт хөшөөний дээр тусгай асар барьж хамгаалж

байсан сонирхолтой мэдээ тэмдэглэсэн байдаг. Мөн тэрээр уг дурсгалыг үзэж байхдаа, өмнөх судлаачдын олж үзээгүй нэг хүн чулууг шинээр илрүүлэн олж Санкт-Петербург хотод аваачсан нь Эрмитаж музейн сан хөмрөгт байдаг аж.

1920-1930 аад онд буриад эрдэмтэн Б.Бамбаев, зөвлөлтийн судлаач Д.Д.Букинич нар Архангай аймгийн нутаг Хангайн нурууны Тэрхийн цагаан нуур, Хөдөө нуур, Хар хул хааны балгас орчим, Хануй, Хүнүйн билчир зэрэг олон газарт өмнө илэрч олдсон дурсгалуудыг нягтлан үзэхийн сацуу шинээр олон хүн чулуу, тахилын онгон илрүүлэн олж эрдэм шинжилгээний тодорхойлолт хийж, гэрэл зураг авч, гар зураг зурсанаа өөр өөрсдийн зохиол бүтээлд оруулсан байдаг. Мөн тэрээр анх И. Падериний олж илрүүлсэн хэмээх одоогийн Хотонт сумын нутагт Орхон, Жирмэнтэй хоёр голын бэлчирт орших Уйгур улсын нийслэл Хар балгас буюу Орду балык хотын туурийн орчим бага хэмжээний малтлага судалгаа хийжээ.

Үүнээс хойш 1949 онд С.В.Киселев, Х.Пэрлээ нарын удирдсан Монгол-Зөвлөлтийн хамтарсан шинжилгээний анги энэ хотын туурьд малтлага хийж эрдэм шинжилгээний олон чухал олдвор цуглуулсан бол 1970-аад онд Д.Цэвээндорж, Ю.С.Худяков нарын бүрэлдэхүүнтэй МЗТСХЭ-ийн хэсэг хайгуул хийж шавар ваар эдлэлийн судалгаа хийжээ.

О. Намнандорж 1953 онд Архангай, Сэлэнгэ аймгийн нутагаас тус бүр нэг эвдэрсэн хүннү булш олсноо малтсан судалсан байдаг. Эдгээр нэг болох Архангай аймгийн Хашаат сумын Гашууны голын булшнаас хүний яс, шавар ваар зэрэг олворуудыг илрүүлэн олжээ.

1956-1957 онд археологич Ц.Доржсүрэн Архангай аймгийн Хайрхан сумын Дэлэн толгой гэдэг газар элсэн манхнаас неолитын суурин илрүүлэн олж ялтсан хутга, хусуур, сумны зэв, чулуун сүх, загасны торны чулуун хүндрүүлэгч, улаан өнгийн шавар ваарны хагархай зэргийг илрүүлсэн ба мөн Баян-Улаан сумын /өнөөгийн Батцэнгэл Г.А/ Тоглохын тал, Эрдэнэмандал сумын Хануйн гол, Булган, Архангай аймгийн зааг нутагт буй Шивээт Улааны цогцолбор дурсгалын зэрэг өмнөх судлаачдын үзэж тэмдэглэж байсан дурсгалуудыг давтан үзэж нийтэлжээ. Тэрээр Архангай аймгийн Бугат сумын нутаг Хаалгатын ам хэмээх газарт мэлхий чулуун суурьтай бичигт хөшөө бүхий том хэмжээний дурсгалыг малтаж, бичигт хөшөө болон мэлхий чулуун суурийг нь ил гаргасан нь согд, брахми бичээс бүхий манай орон дахь түрэгийн хамгийн эртний тахил тайлгын онгоны дурсгал байсан байна. Мөн тэрээр Архангай аймгийн Тариат сумын нутаг Хойд Тэрхийн голын хойд биед Долоон модны ам гэдэг газрын тушаа нутгийнхан мэлхий чулуу гэж нэрлэдэг Орхоны бичигт хөшөөг илрүүлэн олж малтан шалгаснаар энд бичигт хөшөөний суурь болох чулуун мэлхий байгааг тодруулаад буцааж булсан мэдээ бий.

Түүнчлэн Архангай аймгийн Хайрхан сумын нутаг Хүнүй голын Гол мод хэмээх газар хүннүгийн үеийн 26 жижиг булш малтан судалж шавар ваар сав, төмөр зэв, хүрэл хонх, нимгэн алтан чимэглэл зэрэг олон арван эд өлгийн зүйлс, антропологийн болон палеозоологийн материал илрүүлсэн ба Их Тамир сумын нутаг Алтан сандал уулын орчимд найман дөрвөлжин булш малтан шинжилсэн байна.

Мөн хүннүгийн том булш нэгийг малтаж байгаад нуралт үүссэний улмаас малтлагыг зогсоосон байна. Энэ үеэр тэрээр Ваартын ам, Гол мод, Баян харын орчимд түрэгийн үеийн хэдэн булш малтжээ.

1958 онд Монгол-Чехословакийн хамтарсан шинжилгээний анги Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдам дахь Түрэгийн жанжин Күл Тегиний цогцолборт малтлага судалгаа хийж тус цогцолбор нь 67м x 29 м хэмжээтэй хэрмээр хүрээлүүлэн төв хэсэгт нь 10,25 м x 10,25 м хэмжээтэй шүтээний сүмийг тусгайлан зассан өндөр шороон довжоон дээр барьсан болохыг анхлан тогтоожээ. Энэхүү цогцолбороос дорно зүгт чиглүүлэн 3 км гаруй үргэлжилсэн зэл чулуу тавьснаас 169 нь хадгалагдан үлдсэн ба үүний дотор хүн дүрстэй чулуу гурав байжээ. Мөн хэрэмний доторх талбайд эвдэрч хэмхэрсэн хэд хэдэн хүн чулууны үлдэгдэл байснаас гадна шүтээний сүмийн дотор талд малтаж үзэхэд Күл Тегин жанжин, түүний хатан хоёрын чулуун хөргийн толгойн хэсэг олдсон байна. Хамтарсан малтлага судалгааны ажлын үр дүнг гадаад дотоодод хэвлэн нийтэлсэн бөгөөд Монголын талын ахлагч археологич Н.Сэр-Оджав “Хүлтэгний барилгын хэрэглэгдэхүүн”, “Хүлтэгний булшнаас олдсон хүн чулууны толгой” зэрэг хэд хэдэн бүтээл хэвлүүлсэн байдаг. Үүндээ уг цогцолборын хүн чулуу болон амьтдын дүрс XIII зууны үед бүтэн байсан тухай сонирхолтой мэдээ сэлтийг тэмдэглэсэн байдаг.

1960-аад онд А.П.Окладников, Д.Дорж нарын бүрэлдэхүүнтэй Монголын чулуун зэвсгийн дурсгал судлах анги манай улсын бараг бүх аймгийн нутгийг хамарсан хайгуул судалгаа явуулахдаа Архангай аймгийн нутаг, Хангайн нуруу, Тамирын голын сав Тайхар чулуу зэрэг газраас палеолитын үеийн хэд хэдэн дурсгалт газрыг илрүүлэн олжээ.

1963-1964 онд археологич Д.Наваан, Унгарын эрдэмтэн И.Эрдели нар Эрдэнэмандал сумын нутаг Хана уулын өвөрт эртний түрэгийн үеийн булш, Наймаа толгойд 4 хүннү булшийг малтжээ. Мөн тэд Хашаат сумын нутаг Хутаг ууланд Хүннү булш малтсан бөгөөд энд 1970-аад онд Н.Сэр-Оджав 3 булш малтсан мэдээ бий.

1968 онд Академи Б.Ринчен “Монгол нутаг дахь хадны бичээс, гэрэлт хөшөөний зүйл” хэмээх атлас эмхтгэн нийтлүүлэхдээ Тоньюкук, Күл Тегин, Билгэ хааны дурсгалуудад буй хүн чулуудын гэрэл зургийг хэвлэн гаргахын хамт Архангай аймгийн Өгийнуур сумын Тоглохын талаас олдсон хэмээх хоёр хүн чулууны толгойн зургийг мөн оруулжээ. Эдгээр нь бидний огт үзээгүй зүйл бөгөөд Батцэнгэл сумын Тоглохын талд байдаг хүн чулуут цогцолбортой хамаатай эсэх нь тодорхойгүй байна. Эдгээрийг Зэгстэйд, сумын ОНС кабинетад тавьсан байлаа гэж тэмдэглэжээ.

1974 онд археологич Д.Цэвээндорж Өвөрхангай, Архангай, Увс зэрэг хэдэн аймгийн нутагт цөөнгүй хүннү булш малтсан бөгөөд Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Наймаа толгойд Унгарын археологич И. Эрделийн хамт 5 булш, Хойд Тамирын голын хөндийд буй Гэндэн булаг I хэмээх дурсгалыг малтаж, Гэндэн булаг II хэмээх дурсгалыг тодорхойлон Түрэгийн үеийн зарим хүн чулуудын талаар судалгаа хийснээ хожим И.Эрдели нийтэлжээ.

1975-1980 онд МЗТСХЭ-ийн судлаачид Их Тамир сумын нутаг Шар Булагийн Хужирт гэдэг газрын Нарийн амнаас хуучин чулуун зэвсгийн үед хамаарах чулуун эдлэл илрүүлэн олсон бөгөөд мөн Эрдэнэмандал сумын Хөшөөн талд Уйгурын үеийн мэлхий чулуут тахилын онгон зэргийг малтан судалжээ.

Н.Сэр-Оджавын удирдсан “Хархорумын шинжилгээний анги” Их Монгол улсын нийслэл Хархорумд судалгаа хийх явцдаа Эрдэнэмандал сумын нутагт орших Хар Хул балгасанд судалгаа хийсэн бөгөөд 1980-1982 онуудад тус хотын балгасанд дахин малтлага явуулж, дэвсгэр зургийг хийжээ. Мөн 1984, 1986 онуудад дээрх шинжилгээний анги дахин малтлага судалгаа явуулж Монголын хот суурингийн судалгаанд холбогдох чухал баримт хэрэглэгдэхүүн цуглуулжээ.

1978 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах ангийн археологич Д.Дорж, А.П.Окладников нар Цэцэрлэг хотын орчим, Цэнхэр, Жаргалант сумын нутгаар хайгуул шинжилгээ хийж, Жаргалант сумын нутгаас дөрвөлжин дотор олон цэг, хүний дүрс, зарим хүнийг толгойг нь доош харуулан дүрсэлсэн хадны улаан зосон зураг шинээр олж илрүүлжээ.

1979-1982 онд, МЗТСХЭ-ийн археологич Ю.С.Худяков Монгол нутагт өргөн хэмжээтэй тархсан түрэгийн үеийн чулуун хашлагат тахилын онгонуудыг тусгайлан судлах явцдаа Архангай аймгийн Тариат сумын нутаг Тэрхийн цагаан нуурын дэргэдэх Дадгын өвөлжөө, Нарийн хоолой зэрэг газарт буй чулуун хашлагуудыг судалсны үндсэнд түрэгийн үеийн “эгэл жирийн” хэмээгдэх тахилын онгоны байгууламжийн ангилал хийж, Дадга, Нарийн хоолойн хүн чулуун хөшөөдийг судлан нийтлүүлжээ.

1980-1982 онуудад МЗТСХЭ-ийн хүрэл төмөр зэвсгийн дурсгал судлах анги Архангай аймгийн Батцэнгэл сумын Солби уул, Эзэгийтийн хужир, Худагийн ам, Шивэртийн ам, Гурван модот уул зэрэг газруудад хүннү булш малтжээ.

1982 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн археологич Д.Дорж, Д.Цэвээндорж нар Туул, хойд Тамир, Сэлэнгэ зэрэг томоохон гол мөрний сав газрын нийт 29 газар чулуун зэвсгийн дурсгал, бууц суурин илрүүлснээс хойд Тамир голын савд Эрдэнэ толгой, Харуул толгой, Элстэйн ам, Яргайт, Туулгайт, Бага улаан толгой зэрэг 12 газраас хуучин, шинэ чулууг зэвсгийн олдворууд цуглуулжээ.

1983 онд “МЗТСХЭ-ийн хүрэл, төмрийн түрүү үе судлах анги”-ийн археологич Д.Наваан, Т.Санжмятав, П.Б.Коновалов нар Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Шивэртийн аманд хүрлийн үеийн дөрвөлжин булш малтан судалсан мэдээ байдаг.

1980-аад оны дунд үед МЗТСХЭ-ийн бүрэлдэхүүнд ажилласан археологич В.Е. Войтов, Д. Баяр, түрэг судлаач С.Г.Кляшторный нар Монголын төв нутгаар өмнө нь явсан судлаачдын бичиж тэмдэглэсэн түрэгийн үеийн зарим дурсгалыг дахин судалж тодруулахын хамт шинээр олон тооны дурсгалыг шинээр илрүүлэн олж, тодорхойлолт хийснээс Архангай аймгийн Тариат сумын Хөдөө нуурт буй 2 хүн чулуу, Их Тамир сумын ОНС кабинетад байгаа (Баянцагааны гэдэг) 1 хүн чулуу, Хашаат сумын Хөшөө Цайдамд байдаг Күл Тегиний тахилын онгоны 8, Батцэнгэл сумын Тоглохын талд 3 хүн чулуу зэргийг дахин шинэчлэн зураг, тодорхойлолт хийхийн зэрэгцээ Тариат сумын Хөдөө нуурын 2 хашлага, Хайрхан сумын Хөшөөн тал, Батцэнгэл сумын Шивэртийн ам, Эрдэнэмандал сумын Эрдэнэмандал I-V, Их Тамир суман дахь Бугатын зэрэг олон дурсгалыг малтан судалж, бүтэц, зохион байгуулалт, он цаг, учир холбогдлыг тодруулах ажил хийж, үр дүнг тус тусын зохиол бүтээлдээ нийтэлсэн байна.

1987 онд МЗТСХЭ-ийн шинжилгээний ангийн археологич Т.Санжмятав, Д.Наваан, В.В.Волков нар Их Тамир сумын нутаг Алтан сандал ууланд буган хөшөөтэй дөрвөлжин булш нэгийг малтаж галт уулын хүрмэн чулууг нүхэлж хийсэн зүүлт илрүүлэн олжээ.

Мөн онд Монгол-Унгарын хамтарсан археологийн шинжилгээний анги Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Худагийн толгойд 2, Солби ууланд 2, Эрдэнэмандал сумын нутаг Наймаа толгойд булш малтаж судалжээ.

1989, 1990 онд МЗТСХЭ-ийн шинжилгээний анги Өндөр-Улаан сумын нутаг Хануй голын Жаргалантын аманд олон булш дараасны дунд байгаа ганц буган хөшөө босгосон жижиг булш 1, буган хөшөөгөөр хана хийсэн том булш 1, дөрвөлжин хэлбэрийн нэлээд том булш 1 нийт гурван булш малтан судалсан бөгөөд уг булшнаас 100 орчим малын толгойг аман хүзүүний ястай хамт зүүн зүг хандуулан тавьсан, 4 морины толгой хүрэл зуузайтай суран амгайтай, зэв, зуузай, товруу, тогоо зэргийг олж илрүүлэн эрдэм шинжилгээний тайлан бичжээ.

1993 онд археологич Т.Санжмятав Архангай аймаг байгуулагдсаны 70 жилийн ойд зориулан тус аймагт олон жилийн турш явуулсан судалгааны ажлынхаа үр дүнг нэгтгэн “Архангай аймгийн нутаг дахь эртний түүх соёлын дурсгал” хэмээх ном бичсэн бөгөөд номонд Архангай аймгийн нутгаас илрүүлэн судалсан хуучин чулуун зэвсгийн үеэс XIII зууны Монгол улс хүртэлх түүхэн үеүдийн археологийн дурсгалыг нэгтгэн оруулжээ. Энэхүү “Архангай аймгийн нутаг дахь эртний түүх соёлын дурсгал” бүтээл нь тус аймгийн эртний түүх соёлын дурсгалуудын шинжлэх ухааны үүднээс судлахын сацуу энэ талын ажлыг олон нийтэд сурталчилсан, танин мэдэхүйн чухал ажил болсон байна. Мөн тэрээр хадны зургийн судалгаагаар “Монголын хадны зураг” хэмээн нэгэн сэдэвт бүтээлдээ Чулуут голын хадны зургийг талаар дэлгэрэнгүй оруулсан байдаг.

1998 онд Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн судалгааны баг Архангай аймгийн Хотонт сумын төв дэх хүн чулууг үзэж зураг, тодорхойлолт хийжээ.

1997-2004 онд Туркийн Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын (TICA) санхүүжилтээр Монгол-Туркийн эрдэмтдийн хамтарсан “Монгол дахь Түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах, судлах, сэргээн засварлах” төслийн хүрээнд Архангайн Хөшөө Цайдамд буй Билгэ хаан, Күль-Тегиний онгоныг малтан судалж, сэргээн засварласан байна. Энэ ажлын явцад алтан титэм, мөнгөн буга зэрэг олон тооны үнэт олдвор илэрсэн нь манай улсын Үндэсний музейд хадаглагдаж байна.

1998 онд Хотонт сумын нутагт, Орхон голын хойно, Дунд Хутаг уулын арын салбар уулсаас хойш буусан Хулхийн ам, Хундын хоолой, Өвөр хавцлын ам зэрэг газруудад өвөрмөц зохион байгуулалт бүхий дурсгалууд байсныг А.Очир, У.Эрдэнэбат, Ч.Амартүвшин нар илрүүлэн олсон байна. Сүүлд 2005-2008 онд тус сумын нутагт хийсэн хайгуулын явцад Хиргисийн хоолой, Дуганын үзүүр, Олон дов, Харанхуй жалга зэрэг газруудад урьд өмнө илрүүлсэн дөрвөлжингүүдтэй адил зохион байгуулалт, хэлбэр бүхий дурсгалууд байгааг нэмэн олж бүртгэсэн бөгөөд 2006-2008 онд өмнө илрүүлсэн Өвөр хавцлын ам, Хундын хоолойн, Хулхийн ам зэрэг 3 газарт 5 дөрвөлжинг малтан судалж Уйгурын үед холбогдохыг тогтоожээ. Эдгээр дөрвөлжингүүдийн малтах явцад Уйгурын үеийн ханын зураг анх удаа илэрүүлэн олсон байна. 2006 онд дээрхи дөрвөлжингүүдийг малтан судлах явцад Хулхийн амны I дөрвөлжингийн шороон далан дотор хожим үйлдсэн XIII-XIV зууны үед холбогдох найман Монгол булшийг малтаж богтаг малгай, алтан чимэглэл зэрэг эд өлөг илрүүлэн олсон байна.

2000 онд МУИС-ын Антропологи-Археологийн тэнхимийн оюутнууд З.Батсайханы удирдлагаар хээрийн дадлага хийж явах үедээ Архангай аймгийн Өгийнуур сумын Тамирын улаан хошуунд хүннүгийн оршуулгын газар олж, 16 булш малтсанаас 5 бүтэн гавал зэрэг судалгааны чухал хэрэглэгдэхүүн илрүүлсэн бөгөөд мөн Батцэнгэл сумын Эмээл толгойд мөн хэдэн хүннү булш малтсанаас нарийн хурц үзүүртэй зүйлээр сийлсэн ясан эдлэл зэрэг эд өлгийн зүйлс олджээ. Тэрчлэн Өгийнуур сумын нутаг Хэрмэн талд зэрэгцээ 3 хэрэмний туурь, Ар шанд гэдэг газарт нэгэн хэрэмний туурь байгааг тэмдэглэжээ.

2000 оноос эхлэн археологич Ц.Доржсүрэнгийн 1956-1957 онд малтаж байгаад дутуу орхисон Архангай аймгийн Хайрхан сумын нутаг Гол модонд орших хүннүгийн язгууртны 420 булшийг Монгол-Францын хамтарсан археологийн экспедиц зураглалд оруулж, язгууртны гэгдэх 3, дагуул булш 13-ыг тус тус малтан судалжээ.

Мөн 2001 онд археологич Ц.Төрбат Тамирын Улаан хошууны 370 жижиг булш бүхий оршуулгын газарт 2 хүннү булш малтан судалжээ. Судлаач малтлагын хэрэглэгдэхүүнд тулгуурлан Хүннүгийн соёлын орон нутгийн бүлэг хэмээх саналыг дэвшүүлсэн байдаг.

2004 онд МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхимийн багш Ц.Цэцэгжаргал Цэцэрлэг сумын Бух багийн нутагт орших Хүрэмт хэмээх газар орших хадны зургийг судалсан бөгөөд тэнд нийт 12 газарт 1000 гаруй хадны зургийг илрүүлэн олж нийтэлжээ.

2004 онд судлаач А.Очир, Ц.Одбаатар нар Хашаат сумын Номгон багийн нутаг Номгоны хөндийн адгаас эртний түрэгийн үед холбогдох 8 хэсэг газарт орших тахилын онгоны хашлага чулууд, хавтан чулуу, чулуун баримлууд болон зэл чулуу, шороон хэрэм зэрэг дурсгалуудыг илрүүлэн олж хэмжилт, гар зураг, тодорхойлолтыг хийн 2007 онд хэвлэн нийтэлжээ.

2001 онд Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Хануй багийн нутагт Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн профессор Д.Эрдэнэбаатарын ахалсан Монгол-Америкийн хамтарсан “Хануйн хөндий: эртний нүүдэлчдийн бэлчээрийн аж ахуй” төслийн археологийн хээрийн шинжилгээний анги Хануйн голын хөндий Балгасын тал гэдэг газраас, хүннүгийн хаад язгууртны булш бүхий оршуулгын газрыг анх удаа шинээр илрүүлэн олсон байна. Энэхүү шинээр илрүүлэн олсон дурсгалт газар, хүннүгийн хаад язгууртны булшны судалгааны талаар Балгасын тал дахь Гол мод-2-ын хүннүгийн хаад язгууртны булшны судалгаа нэрээр хэвлүүлсэн учраас, археологийн судалгааны зохиолуудад Гол мод-2 хэмээн алдарших болсон билээ. Гол мод-2-т нийт 200 гаруй булштай эдгээрээс язгууртны 1-р булш болон түүний дагуул 30 жижиг булш, 5-р булш буюу язгууртан хүүхдийн нэг булшийг тус тус 2001-2011 онуудад Улаанбаатарын Их Сургуулийн археологийн тэнхимээс зохион байгуулсан археологийн шинжилгээний анги малтан шинжилсэн юм. 2011 оноос “Женко” тур ХХК-ны “Түмэн хишигтэн” компани Гол мод-2-ын 1-р язгууртны булшны малтлага судалгаанд 100 хувийн хөрөнгө оруулалт хийснээр 5 сарын турш малтан шинжилснээр уг 1-р булшны малтага судалгаа бүрэн дуусжээ. Мөн Монгол-Америкийн хамтарсан “Хануйн хөндий: эртний нүүдэлчдийн бэлчээрийн аж ахуй” төслийн багийнхан, 2000-2006 онд Улаанбаатар Их Сургуулийн Археологийн тэнхим хамтран Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Хануй багийн нутаг Хануй голын хойд энгэрт орших Урт булгийн 1-р хиргисүүрийн 1667 орчим дагуул байгууламжаас 12-ыг сонгон малтжээ. Тэрчлэн 2-р хиргисүүрийн 500 орчим дагуул байгууламжийг бүртгэн, зурагжуулан баримтжуулж авсан байна.

2005 онд МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхим АНУ-ийн Саратогагын (Saratoga) Торгоны зам сангийн хамтарсан шинжилгээний баг Өгий нуур сумын нутаг Тамирын улаан хошуунд орших Хүннүгийн үед холбогдох оршуулгын газарт 5 булш малтан судалснаас янз бүрийн эд өлгийн зүйлс олджээ. Эдгээрээс лаган эдлэлүүд болон хүрэл толь зэрэг зарим сонирхол татахуйц олдворуудыг нарийвчлан судалсан байна. Түүнчлэн дээрх шинжилгээний баг өмнө нь илэрч олдсон Хэрмэн талын хэрмэнд сорилтын малталт хийжээ.

Мөн 2005 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал Д.Цэвээндорж тэргүүтэй судлаачид Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хангай нурууны ар Суварга хайрханы салбар уулсаас эх авах Хужиртын гол, Хөх сүмийн гол, Цагаан сүмийн голын дагуу түүх соёлын дурсгалын хайгуул хийж 20 гаруй газраас хадны зураг, буган чулуун хөшөө, хиргисүүр, булш, хот суурин, сүм хийдийн туурь гэх мэт олон тооны дурсгал давтан болон шинээр бүртгэн баримтжуулан, тодорхойлолт хийж зарим дурсгалын гар зургийг зуран тайлан бичжээ.

2006 оноос ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монакогийн Нэн эртний хүн судлалын музейн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний анги Архангай аймгийн Их Тамир сумын нутагт орших Цац толгой орчмын дурсгалуудыг А, В хэсгүүдэд хуваан дэвсгэр зургуудыг хийж, бүртгэн баримтжуулахад А хэсэгт 140 гаруй хиргисүүр, Цацын болон Баянцагааны хөндийд 38 буган чулуун хөшөө байгаа нь тогтоогдсон байна. Мөн баруун урд зүгт 4-5 км зайд орших Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн зарим дүрслэлийг судлахын зэрэгцээ Цацын эргээс 7-8 км зайд шинээр буган чулуун хөшөө болон Баянцагааны хөндийн адагт түүнийг хийх чулуу олборлож байсан газар, эртний түрэг бичээс зэргийг олж илрүүлэн нийтэлсэн байна.

Мөн онд археологич З.Батсайхан тэргүүтэй судлаачид Хашаат сумын нутаг Хөшөө Цайдамын цогцолбор дурсгалаас зүүн урд зүгт 3 км-д орших Шивээ толгойн оройд байх том чулуун байгууламжийг малтан судалж, тус байгууламжийн гадаад, дотоод зохион байгуулалтыг шинжлэх явцад чулуун дараасны дороос толгой, цээж нь хугарч салсан боловч дүрслэл сайтай, завилж суусан байдалтай хүн чулуу илрүүлэн олжээ. Тэрчлэн Шивээ толгойн баруун суганд орших булшнаас хоёрыг сонгож малтан шинжилсэн үр дүнгээ хэвлүүлжээ.

2007 онд Монголын үндэсний музейн судалгааны анги Хотонт сумын нутаг Өвөр хавцалын аманд 3 булш малтан шинжилснээс нэгэн морьтой оршуулга илрүүлсэн бөгөөд археологич Л.Эрдэнэболд, Ц.Одбаатар нар тус булшны хэрэглэгдэхүүнийг нийтлүүлсэн байна.

2008 онд Монголын үндэсний музей, Монголын соёлын биет өвийг хамгаалах нийгэмлэг, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол Улс дахь АНУ-ийн ЭСЯ хамтран Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших Жаргалантын буган хөшөө, хиргисүүр, тахилгын томоохон цогцолборыг сэргээн босгох төслийг хэрэгжүүлж, 21 буган чулуун хөшөөг дахин босгон, тэр орчмын хиргисүүр, тахилын байгууламжийг судалж, он цагийг тогтоох оролдлого хийж, үр дүнгээр нь “Жаргалантын амны буган хөшөөд” хэмээх бүтээл хэвлэн гаргасан байна. 2009, 2010 онд тус хамтарсан шинжилгээний анги Цац толгой, Хөрөөгийн үзүүр орчмоос чулуун зэвсгийн зүйлс түүвэрлэн хуучин чулуун зэвсгийн дээд үед холбогдуулан үзсэн байна.

2008 оны зун Улаанбаатар их сургуулийн Түүх, Археологийн тэнхимийн оюутны хээрийн танилцах дадлагаар Өндөр-Улаан сумын Хануй багийн нутаг Үстийн ам хэмээх газар орших зэрэгцээ хоёр тахилын онгон, хүн чулууг илрүүлэн олж, газарт мөрнөөс доош шигдсэн байсныг малтан гаргаж гар зургийг зурж, гэрэл зургаар баримтжуулалт хийж, нийтлүүлсэн байна.

“Монголын соёлын өв” олон улсын нийгэмлэг, Монголын Урлагийн зөвлөлтэй хамтран 2009 онд хэвлүүлсэн “Монголын сүм хийдийн түүхэн товчоон” бүтээлд Архангай аймгийн нутаг дахь 91 сүм хийдийн мэдээг оруулсан

байна.

2010 онд МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологийн салбарын хээрийн дадлагын хүрээнд Хотонт сумын 3-р багийн нутагт орших Олон дов хэмээх газарт 9 булш, хэд хэдэн байгууламжид малтлага судалгаа хийж, тэндээс илэрсэн олдворт үндэслэн VIII-IX зууны үеийн Уйгурын нийслэл хотын оршин суугчдын оршуулгын газар байж болзошгүй хэмээн үзсэн байна.

МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуулийн Түрэг судлалын тэнхим, Архангай аймгийн Цэцэрлэг сумын нутгийн зөвлөлтэй хамтран тус сумын нутаг дахь түүх соёлын дурсгалыг судлан шинжлэх хээрийн судалгааны анги зохион байгуулж зарим дурсгалуудыг шинээр олж илрүүлсэн ба Ажирга, Туулант голын бэлчрийн тахилын онгон, хүн чулуу (Дадгын тахилын онгон)-ны товч мэдээг нийтлүүлсэн бөгөөд тахилын онгоны хавтан дээр байх руни бичгийг “нутгийн ихэс нэрийг...” хэмээн тайлан уншжээ.

Архангай аймгийн нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт. Тус аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас 1941 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлаас батлан гаргасан “Улсын хамгаалалтад авах дурсгал”-ын жагсаалтын Нэгдүгээр зэрэгт орох дурсгалуудын бүртгэлд:

1. Тайжийн чулуу (Лүн буюу Хашаат сум)
2. Хануйн голын балгас
3. Дойтон толгойн балгаснууд
4. Орхоны Хар балгас
5. Баянголын балгас зэрэг дурсгал орсон бол “Улсын хамгаалалтад авах булшууд” гэсэн хэсэгт Нарийн амны булш, Орхоны хөшөө Цайдам дахь Түргийн Могилан хаан ба Куль Тегин хоёрын пайлуур, Архангай аймгийн Лүн сумын Эрдэнэзуу хэмээх хийд зэрэг 3 дурсгалыг оруулжээ.

Харин БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /СнЗ/-ийн 1971 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын жагсаалт”-ын улсын хамгаалалтад:

Түрэгийн Культеген, Билгэ хаадын бичигт хөшөө, булш (Архангай аймгийн Хашаат сумын Хөшөө цайдамд), Мэлхий чулуу бүхий гэрэлт хөшөө (Архангай аймгийн Тариат сумын нутаг Тэрхийн голд) гэсэн 2 дурсгалыг оруулсан бол тус тогтоолын 2 дугаар хавсралт болох “Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалт”-д

1. Их тамир сумын нутаг дахь Тайхар чулуу
2. Эрдэнэмандал сумын «Хануй» голын хөвөөн дахь Хархул хааны балгас
3. Цэцэрлэг хот дахь С.М.Немойн дурсгалын хөшөө
4. Мөн хот дахь Лениний дурсгалын хөшөө
5. Мөн хот дахь Мөнх алдартны дурсгалын хөшөө
6. Мөн хот дахь Сүхбаатарын дурсгалын хөшөө
7. Аймгийн музей байрлаж буй барилгууд
8. Цэцэрлэг хот дахь Дамдин хувилгааны дуган ...гэсэн 8 дурсгалыг багтаан оруулжээ.

Архангай аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны 1972 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 27 тоот тогтоолоор баталсан сум, хороо, хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлсийн жагсаалтад:

- Цэцэрлэг хотод аймгийн орон нутгийг судлах музейд байгаа Согд бичээс бүхий мэлхийн чулуун хөшөө, Заяын хүрээний Цогчин дуган, урд Тамир голын хөвөөн дэх Майдар чулуу, АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны арын цэцэрлэг дэх ажилчин, малчны баримлууд, Хүүхэд залуучуудын цэцэрлэгт байдаг бөх Билэгтийн баримал, 12 жил бүхий баримлууд, Булган уулын хадны зургууд ба уулын өвөр дэх янгирын баримал, найман жилийн дунд сургуулийн хуучин хашаан дахь пионерын баримал, номын 1-р дэлгүүрийн үүдэн дэх Саальчин баримал, Ленины 100 жилийн ойн дурсгалын самбар, МХЗЭ-ийн 50 жилийн ойн дурсгалын самбар,
- Батцэнгэл сумын Тоглохын тал дахь эртний Монголын хөшөө чулуу, хоёр Тамирын бэлчир дэх Дайр Бор уул, Сүүл толгой дахь сийлбэрт чулуу, Цагдуулын аман дахь хүн чулуун хөшөө, Цол цоргын аман дахь Цоргын дөрвөлжин хэрэм, сумын төвийн бичигт чулуу, Луу гүний хүрээний сүм, дуганууд,
- Булган сумын урд Тамирын хөвөөнд буй бээсийн хүрээний турь балгас, эфү Цэрэнгийн хотын турь болох Тамир хотын балгас, Хөшөөтийн дэнж дэх өндөр хөшөө, сумын төвийн баримлууд,
- Жаргалант сумын Хоолой гэдэг газарт буй Хоолойн дуган, Хоолт гэдэг газрын бичиг зураг бүхий хад чулуу,
- Их Тамир сумын Хануй, Хүнүй гол, Бугатад байдаг Түрэгийн хаадын бичигт хөшөөнүүд, сумын төвийн бугын хөшөө, хуучин Хан Өндөрийн хүрээний турь, Тайхар чулуу ба түүн дээрх олон янзын бичиг,
- Өгий нуур сумын Орхон ба Хөгшин Орхон хоёрын хооронд орших Чилин хийдийн чулуун балгас,

- Орхоны зүүн ба баруун этгээдэд орших дөрвөлжин (шороон) хэрэм, Орхон голын ойролцоо орших Дайт (Дойт) Орогийн нуур (Дойтын цагаан нуур),
- Тариат сумын Довын аман дахь хүн чулуун хөшөө, Мөстийн аман дахь өндөр булшнууд, Тариатын хөндий дэх Тариатын хүрээний балгас турь, Өлийн аман дахь хөшөө чулуунууд, Улаан чулуут, Босго, Алтайд зэрэг газруудад байдаг Сэнжит цохионууд,
 - Өндөр-Улаан сумын Цагаан булаг, Далт гэдэг газруудад байдаг хүн чулуун хоёр хөшөө,
 - Төвшрүүлэх сумын Хөх сүмийн гол дахь XIII зууны үеийн Хөх сүмийн балгас,
 - Хайрхан сумын Хануй гол дахь Хар хул хааны хот балгад, Уртын шуудуу гэдэгт буй бичигт хөшөө чулуу, Жаргантайд байдаг бичигт хад, Эмээл толгой дахь хүн чулуун хөшөө, Хануй Хүнүйн бэлчирт буй Жанцант ламын хүрээний турь, Хиргисийн хөндий болон Гүнжийн адаг дахь хөшөө чулуу,
 - Хангай сумын Онхо гэдэг газарт буй бичигт хөшөө чулуу, Зоо гэдэг газарт буй Зоогийн хүрээний буйр турь, Ханын аман дахь их хиргис булшнууд.
 - Хотонт суманд Уйгарын нийслэл байсан Орхоны Хар балгас, Хужиртын давааны ар дахь Чавганцын хөшөө, Ар Жаргалантын эхэн дэх Төвхөн хийдийн балгас, Хийд гэдэг газарт буй хоёр суварга,
 - Чулуут сумын Өлзийт голын Бугатад буй бугын зурагтай хад, Хүрээний гол дахь ноёны бунхан, Чулуут голын хөвөөнд Шиваа Ширээтийн хүрээний турь.
 - Цэнхэр сумын Хөшөөтөд болон Цохын аманд зурагт хөшөө чулуу ба олон булш бий.
 - Цэцэрлэг сумын Бухын бригадын нутагт Бух чулуу гэдэг чулуу бий.
 - Эрдэнэмандал сумын Хануй гол, Бичигт хангайд бичигтэй хад, Бор бургастад Бор бургасны дуганы турь, тус сумын 2-р бригадын нутагт байдаг Маймай (Наймаа) толгой, Хар Хул хааны балгас зэрэг түүх, соёлын дурсгалт газрууд бий.
 - Хашаат сумын Цайдамын хөндийд тойрог хүрээтэй булш олон бий. Мөн сумын төвд намын анхны үүр байгуулсан дурсгалын тэмдэг сэлт байдаг.
 - Өлзийт сумын нутаг дахь Орхон голын хөвөөнд хуучин Өөлд бээсийн хүрээний турь, балгас бий. Цэцэрлэг хотод В.И.Лениний, С.М.Немойн мөнх алдартны дурсгалын хөшөөнүүд тус аймгийн музейн байшингууд, Дамдин хувилгааны байшин... гэсэн дурсгалуудыг хамгаалалтад авсан байна. Энэхүү тогтоол нь анх удаа өөрийн аймгийн нутаг дээрх түүх, соёлын дурсгалуудаа хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн чухал шийдвэр байсан юм.

1994 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг батлан гаргасны дараа Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолоор хуучин СнЗ-ийн 1971 оны 420 дугаар тогтоолыг шинэчлэн “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт” нэрээр баталжээ. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д Архангай аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтанд:

- 1.Хашаат сумын Хөшөө цайдам гэдэг газар орших Түрэгийн үеийн Культегин, Билгэ хааны бичигт хөшөө булш
- 2.Тариат суманд Тэрхийн гол орчимд байсан, одоо Шинжлэх ухааны академид хадгалагдаж буй мэлхий суурьтай түрэг бичигт хөшөө
- 3.Хотонт сумын нутагт орших Уйгарын Хар балгас
- 4.Хайрхан сумын Могой-ус гэдэг газар орших Уйгарын Моюнчурын бичигт хөшөө
- 5.Батцэнгэл сумын Цацын эрэг гэдэг газар орших таван бугын хөшөөтэй дөрвөлжин булш
- 6.Ихтамир сумын нутагт орших эртний бичээст Тайхар чулуу
- 7.Эрдэнэмандал сумын Жаргалант гэдэг газар орших буган хөшөөт хиргисүүрийн цогцолбор
- 8.Батцэнгэл сумын Худгийн толгой гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнууд
- 9.Тариат сумын Чулуут гэдэг газар орших сүг зурагтай хад
10. Хайрхан сумын Гол мод гэдэг газар орших Хүннүгийн язгууртны булш
11. Эрдэнэбулган сумын төвд орших Заяын гэгээний хийдийн цогцолбор
12. Эрдэнэмандал сумын нутагт орших Хархул хааны балгас

Аймгийн хамгаалалтанд:

1. Батцэнгэл сумын төвд орших Луу гүний хүрээний дуганууд
2. Өлзийт сумын төвд орших Бишрэлт гүний хүрээний дуганууд
3. Тариат сумын нутаг орших Равжаагийн дуганууд
4. Эрдэнэбулган сумын төвд орших Дамдин хувилгааны дуган
5. Хотонт сумын нутагт орших Хатан шивээ
6. Хайрхан сумын Маймаа толгой гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнууд
7. Өгийнуур сумын нутагт орших Өгийнуурын балгас
8. Тариат сумын Дадгын өвөлжөө гэдэг газар орших хүн чулуу
9. Эрдэнэмандал сумын Хануй голын хөндийд орших Орхон бичээст хашлага чулуу, хүн чулуунууд
10. Хайрхан сумын нутагт орших Их Асгатын бичигт хөшөө
11. Эрдэнэмандал сумын Баруун дэнж гэдэг газар орших хүн чулуу хашлага
12. Өндөр-Улаан сумын Чулуут голын бэлчирт орших сүг зурагтай хад
13. Хотонт сумын төвд орших бичигт хөшөө

14. Хашаат сумын Цагаан хад гэдэг газар орших сүг зурагтай хад
15. Хашаат сумын Их Номгоны хиргисүүр гэдэг газар орших хүн чулуу
16. Хашаат сумын Бага Номгоны урд бэлд орших хүн чулуунууд
17. Хашаат сумын Их Номгон гэдэг газар орших бичигт хад
18. Хашаат сумын Урд Сэртэн гэдэг газар орших сүг зурагтай хад
19. Өлзийт сумын Хөшөөтийн дэнж гэдэг газар орших чулуун хөшөө
20. Өлзийт сумын Бадагт гэдэг газар орших Олзотын балгас
21. Өлзийт сумын Бадагт гэдэг газар орших Хөх чулууны хярын сүг зурагтай хад
22. Хайрхан сумын Гүнжийн аманд орших буган чулуун хөшөө
23. Хайрхан сумын Эмээл толгой гэдэг газар орших хүн чулуу
24. Эрдэнэмандал сумын Уртын аманд орших буган чулуун хөшөө зэрэг нийт 36 дурсгалыг оруулан баталжээ.

1995-1998 онд УИХ-аас “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль”-д зарим өөрчлөлт оруулж шинээр аймаг, сум байгуулсан, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд хамгаалалтад оруулах шаардлагатай дурсгалууд шинээр илэрч олдсон зэрэг шалтгааны улмаас 1994 онд баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэх шаардлага урган гарч ирсэн байна. Энэ шаардлагыг харгалзан Монгол улсын Засгийн газар 1998 оны 235 дугаар тогтоолоор “Улс аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэн баталжээ. Уг жагсаалтад Архангай аймгийн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтанд:

1. Батцэнгэл сумын Цацын дэнж гэдэг газар орших 6 ширхэг буган хөшөө, булш, хиргэсүүрүүд
2. Батцэнгэл сумын Худагийн толгой гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнууд
3. Их тамир сумын нутагт орших эртний бичээст Тайхар чулуу
4. Хайрхан сумын Гол мод гэдэг газар орших Хүннүгийн язгууртны булш
5. Хашаат сумын Хөшөө цайдам гэдэг газар орших Түрэгийн үеийн Культегин, Билгэ хааны бичигт хөшөө, булш
6. Хотонт сумын нутагт орших Уйгарын Хар балгас
7. Хотонт сумын нутагт орших Дойтын толгойн туурь
8. Чулуут, Тариат, Жаргалант, Цэцэрлэг сумын нутгуудад орших Чулуут голын хадны зураг
9. Эрдэнэбулган сумын төвд орших Заяын гэгээний хийдийн цогцолбор Эрдэнэмандал сумын нутагт орших Хархул хааны балгас
10. Эрдэнэмандал сумын Баруун Цүүр гэдэг газар орших буган чулуун хөшөө

Аймгийн хамгаалалтанд:

1. Батцэнгэл сумын төвд орших Луу гүний хүрээний дуганууд
2. Өгийнуур сумын нутагт орших Өгийнуурын балгас
3. Өлзийт сумын төвд орших Бишрэлт гүний хүрээний дуганууд
4. Өлзийт сумын Хөшөөтийн дэнж гэдэг газар орших чулуун хөшөө
5. Өлзийт сумын Бадагт гэдэг газар орших Олзотын балгас
6. Өлзийт сумын Бадагт гэдэг газар орших Хөх чулууны хярын сүг зурагтай хад
7. Өндөр-Улаан сумын Чулуут голын бэлчирт орших буган чулуун хөшөө
8. Тариат сумын Хөдөө нуурын хойд бие Дадаг гэдэг газар орших хүн чулуу
9. Хайрхан сумын Маймаа толгой гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнууд
10. Хайрхан сумын Гүнжийн аманд орших буган чулуун хөшөө
11. Хайрхан сумын Эмээл толгой гэдэг газар орших хүн чулуу
12. Хашаат сумын Их Номгоны Хиргист толгой гэдэг газар орших хүн чулуу
13. Хашаат сумын Бага Номгоны зүүн урд бэл, Номгоны хөндийд орших хүн чулуунууд
14. Хашаат сумын Номгон гэдэг газар орших бэхэн зураг, бичиг
15. Хашаат сумын Урд Сэртэн гэдэг газар орших сүг зурагтай хад
16. Хотонт сумын төвд орших бичигт хөшөө, хүн чулуу, буган чулуу бүхий чулуун дурсгалууд
17. Эрдэнэбулган сумын төвд орших Дамдин хувилгааны дуган
18. Эрдэнэмандал сумын Хануй голын хөндий, Их нуурын хойд биед орших Орхон бичээст хашлага чулуу, хүн чулуунууд
19. Эрдэнэбулган сумын Булган ууланд байдаг зурагтай хад
20. Эрдэнэмандал сумын Уртын аманд орших буган чулуун хөшөө
21. Эрдэнэмандал сумын Урд Жаргалант гэдэг газар орших буган чулуун хөшөөн хашлагат булш, хиргисүүр...гэсэн нийт 32 дурсгалыг оруулжээ.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг сүүлийн 10 гаруй жилийн туршид шинээр илэрч олдсон олон арван дурсгалаар баяжуулан шинэчлэн баталсан юм. Архангай аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас уг жагсаалтын улсын хамгаалалтанд:

1. Батцэнгэл сумын Цацын дэнжийн буган чулуун хөшөө, булш, хиргисүүрийн цогцолбор дурсгал
2. Батцэнгэл сумын Худагийн толгойн Хүннүгийн үеийн булшнууд
3. Ихтамир сумын Алтан сандал уулын орчмын хүн чулуун хөшөө, буган чулуун хөшөө, дөрвөлжин булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал
4. Их тамир сумын нутагт орших эртний бичээст Тайхар чулуу
5. Өндөр-Улаан сумын Балгасан талын Хүннүгийн язгууртны оршуулгын газар
6. Хайрхан сумын Гол мод хэмээх газар орших Хүннүгийн язгууртны булш
7. Хашаат сумын Хөшөө Цайдам гэдэг газар орших Түрэгийн үеийн Культегин, Билгэ хааны бичигт хөшөө, онгон
8. Хотонт сумын нутагт орших Дойтын толгойн туурь
9. Хотонт сумын Баянголын аманд орших Дөрвөлжингүүд гэдэг бунхант булшнууд
10. Хотонт сумын нутагт орших Уйгарын Хар балгас, түүний бичээст хөшөөний үлдэгдэл хэсгүүд
11. Чулуут, Тариат, Жаргалант, Цэцэрлэг сумдын нутагт орших Чулуут голын хавцлын хадны зураг
12. Эрдэнэбулган сумын төвд орших Заяын гэгээний хийд, чонон хөшөө
13. Эрдэнэмандал сумын нутагт орших Хархул хааны балгас
14. Эрдэнэмандал сумын Баруун Цүүр гэдэг газар орших буган чулуун хөшөө

Аймгийн хамгаалалтанд:

1. Батцэнгэл сумын төвд орших Луу гүний хүрээний дуганууд
2. Батцэнгэл сумын Шивэртийн аманд орших буган чулуун хөшөө, дөрвөлжин булшнууд
3. Ихтамир сумын Баянцагаан хэмээх газар орших буган чулуун хөшөөд
4. Өгийнуур сумын нутагт орших Өгийнуурын балгас
5. Өлзийт сумын төвд орших Бишрэлт гүний хүрээний дуганууд
6. Өлзийт сумын Хөшөөтийн дэнж гэдэг газар орших буган чулуун хөшөө
7. Өлзийт сумын Бадагт хэмээх газар орших Олзотын балгас
8. Өлзийт сумын Бадагт хэмээх газар орших Хөх чулууны хярын хадны зураг
9. Өндөр-Улаан сумын Хануй голын хөндийн хиргисүүр, буган чулуун хөшөө бүхий цогцолбор дурсгал
10. Өндөр-Улаан сумын Чулуут голын бэлчирт орших буган чулуун хөшөө
11. Тариат сумын Хөдөө нуурын хойд тал Дадаг хэмээх газар орших хүн чулуун хөшөө
12. Хайрхан сумын Маймаа толгой хэмээх газар орших Хүннүгийн үеийн булш
13. Хайрхан сумын Гүнжийн аманд орших буган чулуун хөшөө
14. Хайрхан сумын Уртын аманд орших буган чулуун хөшөө
15. Хайрхан сумын Эмээл толгойн хүн чулуун хөшөө
16. Хашаат сумын Их номгоны Хиргист хоолойн хүн чулуун хөшөө
17. Хашаат сумын Бага Номгоны хөндийн зүүн урд бэлд орших хүн чулуун хөшөөнүүд
18. Хашаат сумын Их Номгон хэмээх газар орших хадны зураг, бичиг
19. Хашаат сумын Урд сэртэн хэмээх газар орших хадны зураг
20. Хотонт сумын төвд орших хүн чулуун хөшөө, буган чулуун хөшөө бүхий чулуун дурсгалууд
21. Эрдэнэбулган сумын төвд орших Дамдин хувилгааны дуган
22. Эрдэнэбулган сумын Булган уулын бурханы зосон зураг
23. Эрдэнэмандал сумын Их нуурын хойд биед орших Орхон бичээст хашлага чулуу, хүн чулуун хөшөөд
24. Эрдэнэмандал сумын Их Жаргалантын буган чулуун хөшөө, булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал зэрэг нийт 38 дурсгалыг оруулсан байна.

Мөн Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Тоглохын талд орших түрэгийн үеийн тахилын цогцолбор дурсгалт газраас Занбазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд 1969 онд чулуун хонь, 1993 онд хүн чулуун хөшөө зэрэг дурсгалыг татан авчирч, олон нийтэд дэлгэн үзүүлж байна.

In the frame of "Project for research and restoration of Turkish monuments in Mongolia" implemented by the Mongolian and Turkish Governments since 1997, archeological findings were discovered from complex monument of Kültegin and Bilge khan and restored, as well as broken parts of inscription monuments were gathered, inscription monuments were consolidated. As a result of this project, the new museum "Khoshoo Tsaidam" was established in 2010.

In 2007, the Center of Cultural Heritage made copy for inscription monument of Bugat to keep at the province museum. In addition, center has put stone interpretative panels around the deer stone at mountain Altan sandal, petroglyphs of Tairkhar chuluu and petroglyphs of river Chuluut.

According to museum display planning of Kharkhorum museum with the goal of moving the stone monuments from territory of Övörkhongai and Arkhangai province, the following stone monuments, such as an inscription monument with Chinese script at center of Khotont soum, a stone statue with dragon nose figure from ruin of Khar balgas, 6 parts of broken inscription monuments from Uighur's Khar balgas were moved to the grounds of the Kharkhorum museum by the Center of Cultural Heritage in 2010.

With state support, in 2011 province museum or temple of Züün semchin and in 2013 temple Güden at monastery of Zayayn geegen were restored by company Süld Uul.

In 2011-2012, as part of the Mongolian and Monaco joint archeological research project, the company "Süld uul" has restored the roof of temple Khölgjin süm at monastery Zayayn geegen.

Inventory and registration of immovable properties in 2012: In the framework of the registration and documentation work, a team consisting from specialists and experts of the Center of Cultural Heritage has worked in 19 soums of Arkhangai province from 8th of June to 8th of July and 11th of September to 11th of October, 2012. The team has registered over 7200 new and repeat immovable properties at 320 historical sites and documented them by 19000 digital photos, 216 film, over 20 hand drawings and 360 minutes videotaping. The team has travelled 10000 kms in Arkhangai province.

Aiming to cooperate with the locals, we gave methodological advice on immovable properties registration, information, protection and monitoring. And we enriched some local museums collections with Neolithic tools and other findings that were newly discovered during this registration and documentation work.

We would like to thank all the people who have contributed to and worked on this project of registration and documentation of immovable properties of Arkhangai Province. We want to thank all the employees of the Museum, Cultural center, Administration, related organizations and inspector of natural and environmental, herders and the people of Arkhangai Province.

Архангай аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын байршил



БАТЦЭНГЭЛ СУМ

Батцэнгэл сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Батцэнгэл уулын хошуунаас салган байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 3339 мянган га газар нутагтай, 3.7 мянган хүн амтай, 194.8 мянган толгой малтай байна. Сумын төв Жаргалант суурин нь аймгийн төвөөс зүүн хойш 65 км зайтай оршдог.



1. Бага Барчингийн хиргисүүр
2. Барчингийн завсарын булш, хиргисүүр
3. Баян уулын булш, хиргисүүр
4. Булгын шуудууны буган чулуун хөшөөд
5. Дайр бор уулын булш, хиргисүүр
6. Дугуйн амны хүн чулуун хөшөө
7. Дунд Оорцог уулын хүннүгийн оршуулгын газар
8. Дунд Уулын буган чулуун хөшөө, тахилын онгон
9. Зосын үзүүрийн хэрэм
10. Их Үнэгдэйн хадны зураг, төвд бичээс
11. Луу гүний хүрээ
12. Тоглохын талын цогцолбор дурсгал
13. Тээлийн амны буган чулууд, тахилын онгон
14. Усангийн амны тахилын онгон
15. Хөх эргийн тахилын байгууламж, хүн чулуун хөшөө
16. Худагийн толгойн тахилын онгон
17. Худагийн толгойн хүннүгийн оршуулгын газар
18. Хэрмийн хөндийн туурь
19. Цагаан чулуутын хөндийн тахилын онгон
20. Цагд уулын хүн чулуун хөшөө
21. Шивэртийн амны цогцолбор дурсгал
22. Эмээл толгойн булш, хиргисүүр
23. Энхтайваны эрүүний булш, хиргисүүр, буган чулуун хөшөөд
24. Эзэгийтийн хужиртын хүннүгийн оршуулгын газар

1. Бага Барчингийн хиргисүүр

Сумын төвөөс зүүн зүгт 6 км-т, Бага Барчингийн зүүн талд 10 орчим хиргисүүр бий. Энд ихэвчлэн дөрвөлжин болон дугуй хүрээтэй хиргисүүр орших бөгөөд зарим хиргисүүрийн дөрвөн буланд чулуун овоолго бүхий байгууламж байна.



Бага Барчингийн хиргисүүр (зүүн урдаас)



Бага Барчингийн хиргисүүр (баруун урдаас)

2. Барчингийн завсарын булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн урд зүгт 5 орчим км-т, Барчингийн завсар хэмээх газар 30 гаруй хүннү булш, тэдгээрийн ойролцоо дөрвөн буландаа хөшөө чулуутай, голын дараас нь төдийлөн өндөргүй 10-аад булш, дөрвөлжин болон дугуй хүрээтэй хиргисүүр 20 гаруй бий.



Барчингийн завсарын булш, хиргисүүр (хойнаас)

3. Баян уулын булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун зүгт 32 орчим км-т, Баян уулын энгэрт хүрэл зэвсгийн үеэс Монголын үе хүртлэх 50 гаруй булш, тахилын байгууламж бий.



Баян уулын чулуун байгууламж (урдаас)



Баян уулын дөрвөлжин хүрээтэй хиргисүүр (зүүн урдаас)



Барчингийн завсарын булш, хиргисүүр

4. Булагийн шуудууны буган чулуун хөшөөд

Сумын төвөөс зүүн хойд зүгт 10 орчим км-т, Булагийн шуудуу буюу Дулааны булаг хэмээх газарт 2 буган чулуун хөшөөд байх бөгөөд зүүн талынх нь дундуураа хугарсан байдалтай оршино.



Булагийн шуудууны буган чулуун хөшөөд (урдаас)



Булагийн шуудууны буган чулуун хөшөөд

6. Дугуйн амны хүн чулуун хөшөө

Сумын төвөөс хойд зүгт 38 орчим км-т, Дугуйн ам хэмээх газар хөх саарал чулуугаар завилж суугаа хүнийг дүрсэлсэн хүн чулуун хөшөө бий. Одоо хүн чулууны толгой хугарч унан үгүй болсон. Түүний ойр орчмоо хүн чулуун хөшөөг урласан чулуутай адил чулууд байгаа нь тахилын онгоны үлдэгдэл бололтой.



Дугуйн амны хүн чулуун хөшөө (урдаас)

5. Дайр бор уулын булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн урагш 3 орчим км-т, Дайр бор уулын урд энгэрээр цөөнгүй булш, хиргисүүр бий.



Дайр бор уулын булш (баруунаас)



Дайр бор уулын булш (урдаас)



Дугуйн амны хүн чулуун хөшөөний гар зураг (4 талаас)

7. Дунд Оорцог уулын хүннүгийн оршуулгын газар

Сумын төвөөс хойд зүгт 11 орчим км-т, Дунд Оорцог хэмээх багахан толгойн баруун урд энгэрт хойноосоо урагшаа цуварсан байдалтай 100 гаруй хүннү булш бүхий оршуулгын газар бий.



Дунд Оорцог уулын хүннүгийн булш



Дунд Оорцог уулын хүннүгийн оршуулгын газар (урдаас)

8. Дунд уулын буган чулуун хөшөө, тахилын онгон

Сумын төвөөс баруун зүгт 38 орчим км-т, хүүхдийн Тамир зуслангийн зүүн хойно Дунд уул гэдэг газар чулуун овоолго дээр нэгэн буган чулуу хөшөө сул хэвтэнэ. Буган чулуун хөшөөний дүрслэл нэлээд бүдгэрсэн байдалтай.



Дунд уулын тахилын байгууламж, буган чулуу (зүүн урдаас)



Дунд уулын буган чулуу

9. Зосын үзүүрийн хэрэм

Сумын төвөөс хойд зүгт 18 км-т, Зосын үзүүрийн урд, Халзан голын зүүн талд, Талын толгойн баруун хойно шороон хэрэм бий. Тус хэрмийг нутгийн ардууд Зосын үзүүрийн хэрэм хэмээн нэрлэдэг аж.



Зосын үзүүрийн хэрэм (зүүн урдаас)

10. Их Үнэгдэйн хадны зураг, төвд бичээс

Сумын төвөөс зүүн хойд зүгт 27 орчим км-т орших Их Үнэгдэй хэмээх газар хадны зураг бий. Энд буга согоо, мэлхий зэрэг цөөн тооны хадны сийлмэл зураг болон төвд бичиг байх бөгөөд түүнээс хойш 55 м зайд мөн буга, гөрөөс, адуу, янгир гэх мэт зургууд байна.



Их Үнэгдэйн хадны зураг бүхий хад (баруун урдаас)



Их Үнэгдэйн хадны зураг, төвд бичээс



Их Үнэгдэйн хадны зураг

11. Луу гүний хүрээ

Сумын төвд Луу гүний хүрээ буюу одоогийн Тарвачэнболи хийдийн хэд хэдэн дуган оршино.



Луу хүрээний хурлын цогчин дуган (баруун урдаас)



Луу хүрээний дуган (баруун урдаас)

12. Тоглохын талын цогцолбор дурсгал

Сумын төвөөс зүүн урд зүгт 9 км-т, Тоглохын талд Түрэгийн тахилын онгон, хүн чулуу, зэл чулуу, чулуу хонь, ямаа зэрэг амьтаны дүрст хөшөө бүхий цогцолбор дурсгалт газар бий.



Тоглохын талын дурсгалууд (баруунаас)



Тоглохын талын чулуун дурсгалууд

13. Тээлийн амны буган чулууд, тахилын онгон

Сумын төвөөс баруун урд зүгт 15 км-т, Эрдэнэ толгойн баруун талын Тээлийн хөндийд дөрвөн буган чулуун хөшөөд болон тахилын онгон бий.



Тээлийн амны буган чулуун хөшөөд (урдаас)



Тээлийн амны буган чулуун хөшөөд (зүүн урдаас)

14. Усангийн амны тахилын онгон

Сумын төвөөс баруун урд зүгт 39 орчим км-т, Усангийн ам хэмээх аманд тахилын онгон зүүн хойноос баруун урагш чиглэлтэй оршино.



Усангийн амны тахилын онгон (зүүн хойноос)



Усангийн амны тахилын онгон (зүүн урдаас)

15. Хөх эргийн тахилын байгууламж, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун урд зүгт 36 орчим км-т, Хөх эрэг хэмээх газар хүн чулуун хөшөө байна. Нутгийн иргэд энэ газрыг Өртөөн булаг уул гэж нэрлэх нь ч бий. Энд цөөн чулуу газарт шигтгэж хийсэн цагираг хэлбэртэй байгууламж байх бөгөөд түүний ойролцоо газарт сул унасан хүн чулуун хөшөөтэй.



Хөх эргийн хүн чулуун хөшөөний гар зураг



Хөх эргийн хүн чулуун хөшөө (урдаас)

16. Худагийн толгойн тахилын онгон

Сумын төвөөс зүүн зүгт 21 орчим км-т, Худагийн толгойн зүүн урд бөөн дэрсэн дунд Түрэгийн тахилын байгууламж бий.



Худагийн толгойн тахилын онгон (баруунаас)

17. Худагийн толгойн хүннүгийн оршуулгын газар

Сумын төвөөс баруун зүгт 20 орчим км-т, Худагийн толгой хэмээх газарт хүннүгийн оршуулгын газар бий.



Худагийн толгойн хүннүгийн оршуулгын газар (баруунаас)



Худагийн толгойн хүннүгийн булш

18. Хэрмийн хөндийн туурь

Сумын төвөөс зүүн зүгт 15 орчим км-т, Бор Азаргын нурууны өмнө, Шовх уулын хойд хөндийг Хэрмийн хөндий хэмээх бөгөөд энд голдоо овгор бүхий туурь байна. Мөн нутгийн хүмүүс Нам Ухаагийн үзүүр гэж нэрлэдэг аж.



Хэрмийн хөндийн туурь (баруун урдаас)



Хэрмийн хөндийн туурийн зүүн тал

19.Цагаан чулуутын хөндийн тахилын онгон

Сумын төвөөс зүүн зүгт 17 орчим км-т, Цагаан эргийн баруун хөндийд, Цагаан Чулуутын зүүн хөндийд тахилын байгууламж бий.



Цагаан чулуутын хөндийн тахилын онгон (зүүн урдаас)

20. Цагд уулын хүн чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн хойд зүгт 37 орчим км-т, Цагд уулын аманд дүрслэл сайтай нэгэн хүн чулуун хөшөө байна.



Цагд уулын хүн чулуун хөшөө



Цагд уулын хүн чулуун хөшөөний гар зураг

22. Эмээл толгойн булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн зүгт 25 орчим км-т, Эмээл толгойн урд энгэрээр бүлэг хүннү булш болон дөрвөлжин булш, хиргисүүр бий.



Эмээл толгойн хүннү булш (урдаас)



Эмээл толгойн дөрвөлжин булш (зүүн хойноос)

21. Шивэртийн цогцолбор дурсгал

Сумын төвөөс баруун зүгт 35 орчим км-т, Шивэртийн аманд, Хойд тамирын голын урд, тариан талбайн голд олон буган чулуу, дөрвөлжин булш бүхий цогцолбор бий.



Шивэртийн амны буган чулуун хөшөө



Шивэртийн амны буган чулуун хөшөө



Шивэртийн амны цогцолбор дурсгал (урдаас)

23. Энхтайваны эрүүний булш, хиргисүүр, буган чулуун хөшөөд

Сумын төвөөс зүүн урд зүгт 3 орчим км-т, Энхтайваны эрүү хэмээх газар буган чулуу, хиргисүүр булш бий.



Энхтайваны эрүүний буган чулуун хөшөө (зүүн урдаас)



Энхтайваны эрүүний буган чулуун хөшөө



Энхтайваны эрүүний хиргисүүр (баруун урдаас)

24. Эззгийтийн хужиртын хүннүгийн оршуулгын газар

Сумын төвөөс баруун зүгт 25 орчим км-т, Эззгийтийн хужирт хэмээх газар хүннү оршуулгын газар бий. Мөн оршуулгын газрын ойролцоо хиргисүүр бий.



Эззгийтийн хужиртын хүннү булш (урдаас)



Эззгийтийн хужиртын хүннү булш (урдаас)




Эззгийтийн хужиртын хүннү булш



Эззгийтийн хужиртын хиргисүүр (зүүнээс)

БУЛГАН СУМ

Булган сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Эрдэнэбулган уулын хошуунаас салгаж байгуулаад 1952 онд татан буулгаж, Цэцэрлэг хот болон бусад сумдад тараагаад дахин байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 3207 мянган га газар нутагтай, 2.4 мянган хүн амтай, 57.2 мянган толгой малтай байна. Сумын төв Булгийн дэнж суурин нь аймгийн төвөөс баруун урагш 36 км зайтай оршдог.



1. Бунхантын булш, хиргисүүр
2. Майдарын талын бурхан
3. Мараатын эргийн агуй, хадны зураг, булш хиргисүүр
4. Тамир хотын туурь
5. Төгсийн амны тахилын онгон
6. Хавтгай модны тахилын онгон, хүн чулуун хөшөө
7. Хоромсогын амны булш, хиргисүүр
8. Хошготын дэнжийн хөшөө чулуу
9. Хөшөөгийн дэнжийн буган чулуун хөшөө, маанийн үсэгтэй чулуу

1. Бунхантын булш, хиргисүүр

Сумын төвөөс урагш 23 орчим км, Тамир голын хойд эрэг Бунхан хэмээх газар дөрвөлжин болон дугуй хүрээтэй голдоо овоолго бүхий хиргисүүр 20 гаруй бий.



Бунхантын хиргисүүр (баруун урдаас)



Бунхантын хиргисүүр (зүүн урдаас)

2. Майдарын талын бурхан

Сумын төвөөс зүүн хойд зүгт 37 км орчимд Майдарын тал хэмээх газар бурханы чулуун хөшөө бий.



Майдарын талын бурхан (баруун урдаас)



Бунхантын хиргисүүр (баруун урдаас)

3. Мараатын эргийн агуй, хадны зураг, булш хиргисүүр

Сумын төвөөс баруун урд зүгт 37 орчим км-т, Мараатын эрэг хэмээх газарт агуй бий. Энэ агуйн амны ойр орчимд цөөн хэдэн хадны сийлмэл болон зосон зурагтай. Мөн Тамир голын хойд эргийг дагаад олон тооны хиргисүүр, булштай.



Мараатын агуй (урдаас)



Мараатын агуйн амны зосон зураг (урдаас)



Мараатын агуйн орчмын булш, хиргисүүр (зүүн хойноос)

4. Тамир хотын туурь

Сумын төвөөс төвөөс зүүн хойд зүгт 20 км орчимд Тамир хотын туурь оршино. Мөн энэ хотын урд талд Наймаа хотын усан далангийн үлдэгдэл бий.



Тамир хотын туурь (зүүнээс)



Тамир хотын урд талын хэрэм (зүүнээс)



Тамир хотын зүүн талын хэрэм (хойноос)

5. Төгсийн амны тахилын онгон

Сумын төвөөс зүүн хойш 17 орчим км-т, Төгсийн ам хэмээх газар түрэгийн үеийн тахилын онгон бий.




Төгсийн амны тахилын онгон

6. Хавтгай модны тахилын онгон, хүн чулуун хөшөө


Сумын төвөөс урд зүгт 7 орчим км, Тамир голын урд эрэгт Хавтгай модны ар хэмээх газар зүүн талдаа хүн чулуу бүхий хоёр тахилын онгон бий.



Хавтгай модны тахилын онгон (зүүн хойноос)



Хавтгай модны эхний тахилын онгоны хүн чулуун хөшөө



Хавтгай модны хоёр дахь ахилын онгоны хүн чулуун хөшөө

7. Хоромсогын амны булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун урд зүгт 32 км орчим зайд Хоромсогын ам хэмээх уулын урд хормойд 20 гаруй булш, хигисүүр бий.



Хоромсогын амны хиргисүүр (баруун хойноос)



Хоромсогын амны булш, хиргисүүр (баруун хойноос)

8. Хошготын дэнжийн хөшөө чулуу

Сумын төвөөс баруун урагш 29 орчим км, Хошготын дэнж хэмээх өндөр уулсын дундах тэгш дэвсгэг дээр хөх саарал өнгийн байгалийн чулууг засалгүй газарт зоож босгосон хөшөө чулуу бий. Хөшөө чулуун дээр ямар нэгэн дүрслэл байхгүй.



Хошготын дэнжийн хөшөө чулуу (урдаас)

9. Хөшөөгийн дэнжийн буган чулуун хөшөө, маанийн үсэгтэй чулуу

Сумын төвөөс зүүн урд зүгт 6 км орчим зайд Шар ширэнгэ уулын Хөшөөгийн дэнж гэх газар буган хөшөө, маанийн үсэгтэй чулуу бий.



Хөшөөгийн дэнжийн буган чулуун хөшөө (урдаас)



Хөшөөгийн дэнжийн маанийн үсэгт чулуу (урдаас)

ЖАРГАЛАНТ СУМ

Жаргалант сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Рашаант уулын хошуунаас салгаж байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 2833 мянган га газар нутагтай, 4.1 мянган хүн амтай, 125.9 мянган толгой малтай байна. Сумын төв Баянцагаан суурин нь аймгийн төвөөс хойш 230 км зайтай оршдог.



1. Асайтын голын булш, хиргисүүр, хийдийн туурь, төвд бичээс
2. Бугатын хадны сийлмэл зураг, төвд бичээс
3. Далангийн тохойн хиргисүүр, хадны зураг
4. Жаазтайн амны тахилын онгон, булш
5. Жинст хөтөлийн булш, хиргисүүр
6. Зонхов хайрханы бурханы хөрөг, төвд бичээс
7. Марааны булангийн булш, хиргисүүр
8. Хар Марааны булш, хиргисүүр
9. Хоолтын голын адгийн булш, хиргисүүр
10. Хоолтын тахилын онгон, хүн чулуун хөшөө
11. Хөшөөгийн үзүүрийн булш, хиргисүүр

1. Асайтын голын булш, хиргисүүр, хийдийн туурь, төвд бичээс

Сумын төвөөс урд зүгт 30-аад км, Асайтын голыг дагаад баруун, зүүн эргээр олон булш хиргисүүр бий. Мөн энд Асайтын хүрээний туурь байх бөгөөд туурийн арын хаданд цөөн маанийн үсэг бичсэн байдаг.



Асайтын голын маанийн үсэг (зүүнээс)



Асайтын голын хиргисүүр (зүүн урдаас)



Асайтын хийдийн туурь (баруун урдаас)

2. Бугатын хадны сийлмэл зураг, төвд бичээс

Сумын төвөөс баруун зүгт 31-аад км, Бугат хэмээх хадтай өндөр уулын баруун талд байх хадан цохионы урд байх эгц хандан хаданд хэд хэдэн хэсэг газар сийлмэл зургууд байх бөгөөд энд буга, согоо, янгир, үнэг, чоно зэргийг хэд хэдэн янзаар зуржээ. Мөн энд цөөн төвд бичээс байдаг.



Бугатын хад (зүүн хойноос)



Бугатын хадны зураг дахь янгирын дүрслэл



Бугатын хадны зураг дахь бугын дүрслэл



Бугатын хадны зураг дахь янгирын дүрслэл

3. Далангийн тохойн хиргисүүр, хадны зураг

Сумын төвөөс баруун хойд зүгт 32 орчим км, Далангийн тохой гэдэг газар Дэлэн чулуун дээр янгир, давхар онги тамга зэрэг цөөн хадны сийлмэл зураг байна. Эдгээр зураг бүхий хадны дээр орших толгойн хормойгоор цөөн тооны хиргисүүр бий.



Далангийн тохойн хиргисүүр (баруун урдаас)



Далангийн тохойн хадны зураг

4. Жаазтайн амны тахилын онгон, булш

Сумын төвөөс урд зүгт 17 орчим км, Жаазтайн аманд чулуун дараас бүхий хэд хэдэн булш байх бөгөөд заримыг зэрэгцүүлэн үйлдсэн бололтой харагдана. Тэдгээрийн дунд нэг хөшөө чулуутай түрэгийн үеийн бололтой булш бий.



Жаазтайн амны тахилын онгон (зүүн хойноос)



Жаазтайн амны булш (зүүнээс)

5. Жинст хөтөлийн булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун зүгт 31 орчим км, Жинсийн хөтөл дээр хиргисүүр, булш олон байна. Энд хүрээгүй болон дөрвөлжин, дугуй хүрээтэй хиргисүүр 10 гаруй бий.



Жинст хөтөлийн булш , хиргисүүр (урдаас)



Жинст хөтөлийн булш , хиргисүүр (хойноос)

6. Зонхов хайрханы бурханы хөрөг, төвд бичээс

Сумын төвөөс урд зүгт 30 орчим км, Хөшөөтийн амны Зонхов хайрхан хэмээх араараа модтой хад бүхий өндөр уулын өмнө талд тэгш хадан дээр Богд зонховын зурмал зураг байна. Бурханы хөргийг хэдэн жилийн өмнө сэргээн дахиж зурсан байна. Мөн түүний ойр орчимд жижиг бурханы хэд хэдэн зураг, төвд бичээс бий.



Зонхов хайрханы бурханы хөрөг (урдаас)



Зонхов хайрханы бурханы хөрөг, төвд бичээс

7. Марааны булангийн булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун хойд зүгт 26 км орчим зайд Марааны булан гэдэг газар дөрвөлжин хүрээтэй хиргисүүр, дугуй дараастай булш бий.



Марааны булангийн булш, хиргисүүр (хойноос)



Марааны булангийн булш

8. Хар Марааны булш, хиргисүүр

Сумын төвөөс хойд зүгт 26 орчим км, Хар Марааны булан гэдэг газар дөрвөлжин хүрээтэй 4 хиргисүүр, дугуй дараастай 1 булш бий.



Хар Марааны том хиргисүүр (баруун урдаас)



Хар Марааны булш (баруун урдаас)

9. Хоолтын голын адгийн булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун зүгт 30 орчим км, Хоолтын голын адагт айлын байшин хашааны өмнө талд хиргисүүр булш байна. Зарим хиргисүүрийн хажууд дөрвөлжин булш бий.



Хоолтын голын дөрвөлжин хүрээтэй хиргисүүр (урдаас)



Хоолтын голын дөрвөлжин хүрээтэй хиргисүүр

10. Хоолтын тахилын онгон, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс хойш 25 орчим км-т, Хоолтын Хүн чулууны бэл гэдэг газар тахилын онгон, хүн чулуу бий.



Хоолтын тахилын онгон, хүн чулуун хөшөө (баруун хойноос)

11. Хөшөөгийн үзүүрийн булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун зүгт 30 орчим км, Хөшөөгийн үзүүрт, Чулуутын голын урд эргээр дугуй, дөрвөлжин хүрээтэй хиргисүүр, дөрвөлжин хэлбэрийн дараастай, дөрвөн буландаа чулуу босгосон булш бий.



Хөшөөгийн үзүүрийн хиргисүүр (зүүн урдаас)




Хөшөөгийн үзүүрийн хиргисүүр (баруун хойноос)



Хоолтын хүн чулуун хөшөөний гар зураг




Хөшөөгийн үзүүрийн булш



Хоолтын хүн чулуун хөшөө

ИХ ТАМИР СУМ

Их Тамир сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Хан-Өндөр уулын хошуунаас салгаж байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 4847 мянган га газар нутагтай, 5.2 мянган хүн амтай, 186.5 мянган толгой малтай байна. Сумын төв Заан хошуу суурин нь аймгийн төвөөс хойш 30 км зайтай оршдог.



1. Алтан сандал уулын буган чулуун хөшөө
2. Алтан сандал уулын тахилын онгонь хүн чулуун хөшөөд
3. Бага Хавчигийн амны булш, хиргисүүр, буган чулуун хөшөөд
4. Баянцагаан уулын булш, хиргисүүр
5. Баянцагааны талын буган чулуун хөшөөд, хиргисүүр
6. Булгын амны тахилын онгон, хөшөө чулуу
7. Гэндэн булгын амны тахилын онгон, буган чулуун хөшөө
8. Жаргалантын амны булш, хиргисүүр, буган чулуун хөшөө
9. Сумын төвийн буган чулуун хөшөө, хүн чулуун хөшөө
10. Сумын төвийн ойролцоох буган чулуун хөшөөд
11. Тайхар чулуу
12. Улаан хадны булш, хиргисүүр, төв бичээс
13. Хан-Өндөрийн хийдийн туурь
14. Хөрөөгийн үзүүрийн хадны зураг
15. Цагаан давааны буган чулуун хөшөө
16. Цацын эргийн булш, хиргисүүр буган чулуун хөшөөд
17. Шивэртийн амны булш, хиргисүүр, буган чулуун хөшөөд

1. Алтан сандал уулын цогцолбор дурсгал

Сумын төвөөс баруун зүгт 15 орчим км-т, Алтан сандал ууланд буган чулуу, булш, хиргисүүр бий. Энд нэгэн буган чулуун хөшөөнд адуу сийлсэн өвөрмөц хөшөө байдаг.



Алтан сандал уулын булш, хиргисүүр (хойноос)




Адуун дүрс бүхий хөшөө чулуу, гар зураг

2. Алтан сандал уулын тахилын онгон, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун зүгт 15 орчим км-т, Алтан сандал уулын баруунтаа түрэгийн үеийн тахилын онгоны үлдэгдэл байх бөгөөд одоо нэлээд эвдэрч хэлбэр дүрсээ алджээ. Үүний ойролцоо хоёр хүн чулуун хөшөө бий.



Алтан сандал уулын хүн чулуун хөшөөд (зүүнээс)



Алтан сандал уулын хүн чулуун хөшөөний гар зураг



Алтан сандал уулын адууны дүрс бүхий хөшөө чулуутай дөрвөлжин булш (урдаас)



Алтан сандал уулын хүн чулуун хөшөө

3. Бага Хавчигийн амны булш, хиргисүүр, буган чулуун хөшөөд

Сумын төвөөс зүүн хойд зүгт 10 орчим км-т, Бага Хавчигийн аманд хиргисүүр, дөрвөлжин булш, 3 буган чулуун хөшөө бүхий цогцолбор бий.



Бага Хавчигийн амны дурсгалт газар



Бага Хавчигийн амны буган чулуун хөшөөд

4. Баянцагаан уулын булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн хойд зүгт 15 орчим км-т, Баянцагаан уулын урд хормойгоор олон хэлбэр төрх бүхий булш, дөрвөлжин болон дугуй хүрээтэй хиргисүүрүүд олон бий.



Баянцагаан уулын булш, хиргисүүр (баруун урдаас)

5. Баянцагааны талын буган чулуун хөшөөд, хиргисүүр

Сумын төвөөс зүүн хойд зүгт 17 орчим км-т, Баянцагаан уулын өмнө талаар олон хэлбэр төрх бүхий булш, дөрвөлжин болон дугуй хүрээтэй хиргисүүр, буган чулуун хөшөө олон бий.



Баянцагааны талын зарим буган чулуун хөшөөд



Баянцагааны талын зарим буган чулуун хөшөөд

6. Булагийн амны тахилын онгон, хөшөө чулуу

Сумын төвөөс зүүн хойд зүгт 20 орчим км-т, Булагийн аманд 2 тахилын онгон, нэгэн хөшөө чулуу бий.



Булагийн амны тахилын онгон, хөшөө чулуу (баруунаас)

7. Гэндэн булагийн амны тахилын онгон, буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн хойд зүгт 20 орчим км-т, Гэндэн булагийн ам орчимд буган чулуун хөшөө, олон зэл чулуу бүхий тахилын онгон бий.



Гэндэн булагийн амны тахилын онгон, зэл чулуу (баруунаас)

8. Жаргалантын амны булш, хиргисүүр, буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн хойд зүгт 8 орчим км-т, Жаргалантын аманд, жалгын баруун дэнж дээр гурван буган чулуун хөшөө, дөрвөлжин булш, дөрвөлжин дугуй хүрээтэй хиргисүүр бий.



Жаргалантын амны буган чулуун хөшөөд (баруун урдаас)



Жаргалантын амны булш, хиргисүүр (хойноос)



Гэндэн булагийн амны буган чулуун хөшөө (хойноос)

9. Сумын төвийн буган чулуун болон хүн чулуун хөшөө

Сумын соёлын төвийн ард, Сум дундын ойн аж ахуйн урд нэг буган чулуун хөшөө, нэг хүн чулуун хөшөө бий. Хүн чулуун хөшөөг тус сумын Гэндэнбулаг гэдэг газраас авчирсан гэдэг.



Буган чулуун хөшөө



Хүн чулуун хөшөө

10. Сумын төвийн ойролцоох буган чулуун хөшөөд

Сумын төвийн хойно 700 м орчимд 2 буган чулуун хөшөө газарт унасан байдалтай байна. Нэг буган чулуун хөшөө нь дундуураа хугарчээ.



Сумын төвийн хойно байх буган чулуун хөшөө (хойноос)



Сумын төвийн хойно байх буган чулуун хөшөө (зүүнээс)

11. Тайхар чулууны дурсгал

Сумын төвөөс зүүн зүгт 3.5 км орчим зайд Хойд Тамирын голын урд талд Тайхар чулуу байна. Тайхар чулуун дээр түүхийн олон үед холбогдох тамга тэмдэг, амьтдын сийлмэл зураг болон улаан зосон зураг болон руни хятад монгол бичгээр бичсэн 150 гаруй бичээс байдаг. Эдгээрийн ихэнхийг нь бэхээр бичиж үлдээсэн байна.



Тайхар чулууны руни, хятад, монгол бичээс

12. Улаан хадны булш, хиргисүүр, төвд бичээс

Сумын төвөөс зүүн урд зүгт 6 км орчимд, Улаан хад хэмээх газар янз бүрийн хэлбэрийн дараас бүхий булш хиргисүүр бий. Мөн энд эгц хаданд 11 мөр бүхий төвд маанийн үсэг байдаг.



Улаан хадны булш, хиргисүүр (урдаас)



Улаан хадны дөрвөлжин булш



Улаан хадны төвд бичээс



Тайхар чулуу (баруун хойноос)

13. Хан-Өндөрийн хийдийн туурь

Сумын төвөөс баруун урд зүгт 28 км орчим зайд Хан-Өндөрийн хүрээний туурь бий.



Хан-Өндөрийн хийдийн туурь

14. Хөрөөгийн үзүүрийн хадны зураг

Сумын төвөөс зүүн хойд зүгт 17 орчим км-т, Хөрөөгийн үзүүр гэдэг газар хадны зураг бий. Хөрөөгийн үзүүрийн хадны зурагт эгнэж зогссон хүмүүс, хоёр дугуйтай морин тэрэг, бамбайн дүрслэл болон загварчилсан буга сонирхолтой дүрслэлүүд бий.



Хөрөөгийн үзүүр



Хөрөөгийн үзүүрийн хадны зургаас

15. Цагаан давааны буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн урд зүгт 14 орчим км-т, мод үржүүлэхийн хашааны ар талд цагаан боржин чулуугаар хийсэн нэгэн буган чулуун хөшөө газарт унасан байдалтай байна.



Цагаан давааны буган чулуун хөшөө (зүүнээс)

16. Цацын эрэгийн булш, хиргисүүр буган чулуун хөшөөд

Сумын төвөөс зүүн хойд зүгт 16 орчим км-т, Тамир голын хойд эрэг, Цацын эрэгт олон төрлийн булш, хиргисүүр, 30 гаруй буган чулуун хөшөөд бий.



Цацын эрэгийн дурсгалууд



Цацын эрэгийн буган чулуун хөшөөд (баруун урдаас)

17. Шивэртийн амны булш, хиргисүүр, буган чулуун хөшөөд

Сумын төвөөс хойд зүгт 19 орчим км-т, Шивэрийн амны адагт дугуй хүрээтэй том хиргисүүр болон тахилын байгууламж, түүний ойр орчимд нийт 6 буган чулуун хөшөө бий.



Шивэртийн амны буган чулуун хөшөөд (баруун хойноос)

ӨГИЙНУУР СУМ

Өгийнуур сумыг 1952 онд Хотонт сумын 3, 4, 5-р баг, Батцэнгэл сумын 1, 12-р баг, Өлзийт сумын 5, 6, 7-р багуудыг оруулж байгуулсан. Тус сум 2012 оны байдлаар 1686 мянган га газар нутагтай, 3.2 мянган хүн амтай, 152.7 мянган толгой малтай байна. Сумын төв Зэгстэй суурин нь аймгийн төвөөс төвөөс зүүн тийш 100 км зайтай оршдог.



1. Гэрсэн уулын булш, хиргисүүр
2. Дөрвөлжингийн хэрэм
3. Ооромбын хийдийн туурь, бурханы хөрөг
4. Сантын булангийн тахилын онгон, хүн чулуун хөшөө
5. Тамирын улаан хошууны хүннүгийн оршуулгын газар, булш хиргисүүр
6. Хар үхэртийн хадны зураг
7. Хөөвөрийн буган чулуун хөшөө
8. Хэрмэн талын 3 хэрэм
9. Чилэн балгас

1. Гэрсэн уулын булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн хойш 20 орчим км-т, Гэрсэн уулын өмнө зүүн урд өвөрт, Өгий нуурын чанх хойно дугуй болон дөрвөлжин хүрээтэй том жижиг хиргисүүр болон дугуй чулуун дараастай жижиг булш олон бий.



Гэрсэн уулын булш, хиргисүүр (баруун урдаас)

2. Дөрвөлжингийн хэрэм

Сумын төвөөс зүүн урагш 5 орчим км-т, нутагт Дөрвөлжин хэмээх газар Шороон хэрэм байна. Хэрэм 200х150 м харьцаатай, хэрмийн өргөн 20 м, хэрмийн урд талын дунд 20 м сэтэрхийтэй аж.



Дөрвөлжингийн хэрэм (зүүн хойноос)

3. Ооромбын хийдийн туурь, бурханы хөрөг

Сумын төвөөс зүүн хойд зүгт 19 орчим км-т, Баясгалан уулын өвөрт Ооромбын дээд хийдийн туурь байна. Уулын өмнө талд хэд хэдэн барилгын үлдэгдэл болох шороон овоолго бий. Мөн Баясгалан ууланд Очирваань бурхан хадан дээр сийлсэн хөрөг байдаг.



Ооромбын хийдийн туурь, бурханы хөрөг

4. Сантын булангийн тахилын онгон, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун хойш 22 орчим км-т, Сантын булан хэмээх газар түрэгийн үеийн тахилын онгон байна. Хүн чулууг хөх саарал боржин чулуугаар үйлдсэн байх ба хүний ерөнхий төрх болон хамар, нүдний ухархай мэдэгдэнэ.



Сантын булангийн тахилын онгон, хүн чулуун хөшөө (урдаас)

5. Тамирын улаан хошууны хүннүгийн оршуулгын газар, булш хиргисүүр

Сумын төвөөс баруун хойш 14 орчим км-т, Тамирын улаан хошуу хэмээх газар хүннүгийн оршуулгын газар бий. Тус оршуулгын газар хааш хашаа 500 м орчим талбайд хэдэн бүлэг маягтай байх бөгөөд дундуураа гүехэн жалгаар тусгаарлагдсан байдалтай оршино. Мөн энэ орчимд дөрвөлжин булш, хиргисүүр олон бий.



Тамирын улаан хошууны хүннү булш (урдаас)



Тамирын улаан хошууны булш, хиргисүүр (урдаас)

6. Хар үхэртийн хадны зураг

Сумын төвөөс зүүн хойш 21 орчим км-т, Хар үхэртийн бууц хэмээх газарт уулын орой дээр хэсэг хадан дээр сийлмэл зураг бий.



Хар үхэртийн хад (хойноос)



Хар үхэртийн хадны зургаас

8. Хэрмэн талын 3 хэрэм

Сумын төвөөс хойш 10 орчим км-т, Тамирын улаан хошууны баруун талд Хэрмэн тал хэмээх газар зэрэгцээ 3 хэрэм бий.



Хэрмэн талын 3 хэрэм (зүүнээс)

9. Чилэн балгас

Сумын төвөөс зүүн хойш 12 орчим км-т, Өгий багийн нутагт (Амин нуурын хажууд) Чилэн балгас хэмээх эртний шороон хэрэмт хотын үлдэц бий.



Чилэн балгасны гол хэрэм (баруун хойноос)

7. Хөөвөрийн буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн хойш 25 орчим км-т, Хөөвөр хэмээх газар дөрвөн хашлага чулуун дотор буган чулуун хөшөө бий.



Хөөвөрийн буган чулуу хөшөө



Хөөвөрийн буган чулуу хөшөө



Чилэн балгас (баруун урдаас)

ӨЛЗИЙТ СУМ

Өлзийт сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Батцэнгэл уулын хошуунаас салган байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 1720 мянган га газар нутагтай, 3.1 мянган хүн амтай, 149.5 мянган толгой малтай байна. Сумын төв Хөшөөт суурин нь аймгийн төвөөс зүүн тийш 100 км зайтай оршдог.



1. Бага хайрхан уулын булш, хиргисүүр
2. Бичигтийн булш, хиргисүүр, хадны зураг
3. Жаргалантын өвөрийн булш, хиргисүүр
4. Маанийн дэнжийн буган чулуун хөшөө
5. Мөнгөний хөндийн буган чулуун хөшөө
6. Норжин уулын булш, хиргисүүр
7. Олзот уулын булш, хиргисүүр, буган чулуун хөшөө
8. Өөлд Бэйсийн хүрээний барилгын үлдэгдэл
9. Хөшөөтийн дэнжийн буган чулуун хөшөөд
10. Хустайн адгийн булш, хиргисүүр
11. Хүрэн Мандалын зосон зураг
12. Цагаан эргийн булш, хиргисүүр
13. Янгиртын хадны зураг

1. Бага хайрхан уулын булш, хиргисүүр

Сумын төвөөс хойш 13 орчим км-т, Бага Хайрханы уулын энгэр, Орхон голын хойд эрэгт машин замын хажуугаар дөрвөлжин болон дугуй хүрээтэй хиргисүүр 10 гаруй бий.



Бага хайрханы булш, хиргисүүр (зүүн урдаас)

2. Бичигтийн булш, хиргисүүр, хадны зураг

Сумын төвөөс баруун урд зүгт 13 орчим км-т, Бичигт хэмээх газар хадны зураг, хиргисүүр байна. Нутгийн ардууд Оросын мод гэж нэрлэдэг уулын хойд талд хадны зургууд 5-6 хэсэг газарт олон цөөн байдлаар зурагдсан байх бөгөөд ихэнх нь ганц нэгээр болон сүрэглэн яваа янгир бугыг загварчлан дүрсэлсэн ба тамга тэмдгийн дүрсийг нилээдгүй сийлжээ.



Бичигт хад (урдаас)



Бичигт хадны зургаас (урдаас)

3. Жаргалантын өвөрийн булш, хиргисүүр

Сумын төвөөс хойш 6 км-т, Жаргалант уулын өмнөх хөндийг уруудаад том хэмжээтэй хиргисүүрүүд бий.



Жаргалантын өвөрийн хиргисүүр (зүүн урдаас)

4. Маанийн дэнжийн буган чулуун хөшөө

Сумын төвөөс урд зүгт 24 орчим км-т, Маанийн дэнж хэмээх газар айлын хаваржааны ард нэгэн буган чулуун хөшөөн дээр маанийн үсэг сийлэн босгосон байна.



5. Мөнгөний хөндийн буган чулуун хөшөө

Сумын төвөөс баруун зүгт 18 орчим км-т, Мөнгөний хөндий хэмээх газар нэг буган чулуу, гурван түрэгийн үеийн бололтой чулуун овоолго бүхий булш гурван булш болон зүүн өмнө зүгт чиглэсэн хоёр эгнээ зэл чулууд бий.



Мөнгөний хөндийн булш, буган чулуун хөшөө (зүүн хойноос)

6. Норжин уулын булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун хойд зүгт 17 км орчимд Далдын давааны зүүн хойд дор болон Норжин уулын өвөрт хиргисүүр, дөрвөлжин булш бий.



Норжин уулын булш, хиргисүүр (урдаас)

7. Олзот уулын булш, хиргисүүр, буган чулуун хөшөө

Сумын төвөөс баруун зүгт 19 орчим км-т, Олзотын өвөрт дугуй, дөрвөлжин хүрээ бүхий хиргисүүр 20 орчим, мөн тооны дөрвөлжин булш бий. Мөн энд нэгэн буган чулуун хөшөө хажуу тийш налж унасан байдалтай оршино. Эдгээр дурсгалаас холгүй Олзотын хийдийн туурь байдаг.



Олзот уулын хиргисүүр, буган чулуун хөшөө (зүүн урдаас)



Олзотын хийдийн туурь (урдаас)

8. Өөлд Бэйсийн хүрээний барилгын үлдэгдэл

Өлзийт сумын төвд Өөлд бэйсийн хүрээний үлдэгдэл болох хэд хэдэн барилга бий.




Өөлд бэйсийн хүрээний туурь (зүүн урдаас)

9. Хөшөөтийн дэнжийн буган чулуун хөшөөд

Сумын төвийн зүүн захад Хөшөөтийн дэнж хэмээх газар 3 ш буган чулуун хөшөөд бий.



Хөшөөтийн дэнжийн буган хөшөөд (зүүн урдаас)



Хөшөөтийн дэнжийн 2-р буган чулуун хөшөөний гар зураг

10. Хустайн адгийн булш, хиргисүүр

Сумын төвөөс хойд зүгт 25 км-т, Орхон голын хойд эрэгт Хустайн адагт дугуй болон дөрвөлжин хүрээтэй 10 гаруй хиргисүүр бий.



Хустайн адгийн булш, хиргисүүр (урдаас)

11. Хүрэн Мандалын зосон зураг

Сумын төвөөс зүүн урд зүгт 7 км-т, Хүрэн Мандалын хошуу хэмээх баруун хойшоо харсан огцом хаданд олон хэсэг газар үргэлжлүүлэн хадны зосон зураг, хар бэхээр бичсэн монгол бичиг, маанийн үсэг бий.



Хүрэн Мандалын хошуу (баруунаас)



Хүрэн Мандалын зосон зураг, монгол бичээс



Хүрэн Мандалын хошууны зосон зураг

12. Цагаан эргийн булш, хиргисүүр

Сумын төвөөс хойд зүгт 18 км-т, Орхон голын хойд эрэгт Хустайн адагт дугуй болон дөрвөлжин хүрээтэй 10 гаруй хиргисүүр бий.



Цагаан эргийн булш, хиргисүүр

13. Янгиртын хадны зураг

Сумын төвөөс баруун урд зүгт 18 км-т, Янгирт хэмээх газар ан амьтан, тамга тэмдэгийг дүрслэн зурсан хадны зурагтай.



Янгиртын хадны зураг (урдаас)



Янгиртын хадны зургаас

ӨНДӨР-УЛААН СУМ

Өндөр-Улаан сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Хан-Өндөр уулын хошуунаас салгаж байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 4394 мянган га газар нутагтай, 5.7 мянган хүн амтай, 195.6 мянган толгой малтай байна. Сумын төв Тээл суурин нь аймгийн төвөөс баруун хойш 122 км зайтай оршдог.



1. Азаргын голын булш, хиргисүүр
2. Бичигт хангайн зосон зураг, монгол бичээс
3. Бортын үзүүрийн буган чулуун хөшөө
4. Бөөн бургасны дэнжийн тахилын онгон, хүн чулуун хөшөө
5. Гол Мод 2 Хүннүгийн оршуулгын газар
6. Дашлангийн голын зосон зураг
7. Дэлийн үзүүрийн буган чулуун хөшөө
8. Жаргалантын буган чулуун хөшөөний цогцолбор дурсгал
9. Зүүн амны булш, хиргисүүр. буган чулуун хөшөөд
10. Их Цагаан чулуутын буган чулуун хөшөө
11. Мэлхий толгойн буган чулуун хөшөө
12. Салхитын үзүүрийн хиргисүүр буган чулуун хөшөө
13. Тэргэн толгойн булш, хиргисүүр
14. Урт булгийн булш, хиргисүүр
15. Хиргисүүрийн дэнжийн хиргисүүр, буган чулуун хөшөөд
16. Хөшөөтийн дальтийн буган чулуун хөшөө
17. Сэмжин бавуу хэмээх хүн чулуун хөшөө
18. Шаварын голын тахилын онгон, хүн чулуун хөшөө
19. Шар дугуйн буган чулуун хөшөө

1. Азрагын голын булш, хиргисүүр

Сумын төвөөс хойш 25 орчим км-т, Азаргын голд янз бүрийн хэлбэртэй, олон тооны булш, хиргисүүр бий.



Азрагын голын булш, хиргисүүр (баруунаас)

2. Бичигт хангайн зосон зураг, монгол бичээс

Сумын төвөөс зүүн хойш 50 орчим км, Хануй голд хойшоо түрж орсон хадан хошуут өндөр уулыг нутгийн ардууд “Бичигт Хангай”, “Бичигт Хайрхан”, “Бичигт хошуу” хэмээн нэрлэдэг бөгөөд энд булш, хиргисүүр, зосон зураг, олон төрлийн бичиг зэрэг түүхийн олон үеийн дурсгалууд элбэг бий.



Бичигт хангай уул (зүүн хойноос)



Бичигт хангай уулын зосон зураг



Бичигт хангай уулын монгол бичээс

3. Бортын үзүүрийн буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн хойш 46 км-т, Бортын үзүүрт буган чулуун хөшөө, булш бий.




Бортын үзүүрийн буган чулуун хөшөө (зүүнгээс)

4. Бөөн бургасны дэнжийн тахилын онгон, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс хойш 33 орчим км, Бөөн бургасны дэнж хэмээх газар хүн чулуун хөшөө, тахилын онгон байна. Хүн чулуун хөшөө тахилын онгоны урд талд баруун хойш налж унасан байдалтай.



Бөөн бургасны дэнжийн хүн чулуун хөшөө



Бөөн бургасны дэнжийн хүн чулуун хөшөөний гар зураг

5. Гол Мод 2 Хүннүгийн оршуулгын газар

Сумын төвөөс зүүн зүгт 54 орчим км-т, Хүннүгийн язгууртны томоохон оршуулгын газар бий.



Гол Мод 2-ын хүннүгийн язгууртан булш (зүүн урдаас)

6. Дашлангийн голын зосон зураг

Сумын төвөөс зүүн хойд зүгт 16 орчим км, Олон цохиот уулын урд үзүүр, Дашлангийн голын хойд эрэг орших урд зүг харсан хэдэн үе давхарласан мэт хадан цохионы тэгш гадаргуу дээр 3 хэсэг зосон зураг байна. бий.



Дашлангийн голын зосон зурагт цохио (зүүнээс)



Дашлангийн голын зосон зураг



Гол Мод 2-ын хүннүгийн язгууртан булш

7. Дэлийн үзүүрийн буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн урагш 28 орчим км-т, тэгш талд дөрвөлжин булшны дунд нэгэн буган чулуун хөшөө босгосон бий.



Дэлийн үзүүрийн буган чулуун хөшөө (баруунаас)

8. Жаргалантын буган чулуун хөшөөний цогцолбор дурсгал

Сумын төвөөс зүүн зүгт 54 орчим км-т, Жаргалантын амны адагт 30 гаруй буган чулуу хөшөө бүхий цогцолбор бий.



Жаргалантын цогцолбор дурсгал (урдаас)

9. Зүүн амны булш, хиргисүүр, буган чулуун хөшөөд

Сумын төвөөс зүүн зүгт 39 орчим км, Зүүний ам хэмээх бөгөөд амны эхэнд дугуй болон дөрвөлжин хүрээ бүхий хэд хэдэн хиргисүүр байна. Мөн дөрвөлжин булшинд ашигласан буган чулуун хөшөөн дээр мушгиа цагираг сийлсэн нь сонирхолтой.



Зүүн амны дөрвөлжин булш, буган чулуун хөшөө (урдаас)



Зүүн амны буган чулуун хөшөөд

10. Их Цагаан чулуутын буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн урд зүгт 38 орчим км, Их цагаан чулуутын аманд буган чулуун хөшөө бий.



Их Цагаан чулуутын буган чулуун хөшөө(зүүн урдаас)



Их Цагаан чулуутын буган чулуун хөшөө

11. Мэлхий толгойн буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн урд зүгт 40 орчим км, Мэлхий хэмээх жижиг толгой дээр ухаж сэндийлсэн нүхний хажууд нэгэн буган чулуун хөшөө бий.



Мэлхий толгойн буган чулуун хөшөө (баруун хойноос)

12. Салхитын үзүүрийн хиргисүүр буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн зүгт 36 орчим км, Салхитын үзүүр хэмээх газар олон тооны хиргисүүрүүд, дундуураа хугарсан буган чулуун хөшөө бий.



Салхитын үзүүрийн хиргисүүр (баруун хойноос)



Салхитын үзүүрийн буган чулуу (баруун хойноос)

13. Тэргэн толгойн булш, хиргисүүр

Сумын төвөөс урд зүгт 10 орчим км, Тэргэн толгой хэмээн нэрлэдэг орой дээрээ багахан хадтай толгойн дээхнүүр, дунд хэсгээр 10-аад янз бүрийн хэлбэрийн дараастай булш бий.



Тэргэн толгойн хиргисүүр (баруун урдаас)

14. Урт булагийн булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн урд зүгт 50 орчим км-т Урт булаг хэмээх газар маш олон дагуул байгууламжтай, том хиргисүүр, хэд хэдэн дөрвөлжин булш бий.



Урт булагийн булш, хиргисүүр (зүүн хойноос)

15. Хиргисүүрийн дэнжийн хиргисүүр, буган чулуун хөшөөд

Сумын төвөөс баруун урд зүгт 10 орчим км-т, Чулуут голын хойд эрэг Хиргисүүрийн дэнж дээр том хиргисүүр, буган чулуу бий.



Хиргисүүрийн дэнжийн хиргисүүр (зүүн урдаас)

16. Хөшөөтийн дальтийн буган чулуун хөшөө

Сумын төвөөс сумын төвөөс урд зүгт 36 орчим км-т баруун хойш хазайсан нэгэн буган чулуун хөшөө бий.



Хөшөөтийн дальтын буган чулуун хөшөө (баруун урдаас)

17. Сэмжин бавуу хэмээх хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун хойд зүгт 7 орчим км-т, Цагаан булагийн ам хэмээх уужим хөндийд эвдэрсэн тахилын онгоны дотор хүн чулууны цээжин хэсэг бий. Нутгийн иргэд Сэмжин бавуу хэмээн нэрлэдэг аж.



Сэмжин бавуу хэмээх хүн чулуун хөшөө

18. Шаварын голын тахилын онгон, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун хойд зүгт 10 орчим км, Шаварын голын хойд дэнж дээр тахилын онгон, толгойгүй хүн чулуу болон хиргисүүр булш бий.



Шаварын голын тахилын онгон, хүн чулуун хөшөө

19. Шар дугуйн буган чулуун хөшөө

Сумын төвөөс баруун хойд зүгт 10 орчим км-т, Шар дугуйн дэнж дээр хөх саарал өнгийн чулуугаар үйлдсэн нэгэн буган чулуун хөшөө бий. Мөн энэ буган чулуун хөшөөг нутгийн иргэд Тээлийн голын буган чулуун хөшөө хэмээн нэрэлдэг.



Шар дугуйн дэнжийн буган чулуун хөшөө (баруун хойноос)

ТАРИАТ СУМ

Тариат сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Чандмань Өлзийт далайн хошуунаас салгаж байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 4567 мянган га газар нутагтай, 5.0 мянган хүн амтай, 168.9 мянган толгой малтай байна. Сумын төв Хорго суурин нь аймгийн төвөөс баруун хойш 166 км зайтай оршдог.



1. Бунхантын амны зосон зураг, төвд бичээс
2. Дадгын тахилын онгон, хүн чулуун хөшөөд
3. Дархан уулын булш, хиргисүүр
4. Дунд Нарийн амны хүн чулуун хөшөөд
5. Тариатын голын хиргисүүр
6. Урд хуурайн хиргисүүр, буган чулуун хөшөө
7. Хар усны тохойн буган чулуун хөшөө
8. Хөшөөтийн амны тахилын онгон
9. Хөшөөтийн булш, хиргисүүр
10. Цагаан овооны булш, хиргисүүр

1. Бунхантын амны зосон зураг, төвд бичээс

Сумын төвөөс зүүн хойш 6 орчим км, Бунхантын ам хэмээх газар баруун тийш хандсан адууг том жижиг янз бүрийн хэмжээтэйгээр, хас тэмдэг, хээ, үхэр, гахай бололтой (?) зэрэг янз бүрийн зураг, маанийн үсэг олон бий.



Бунхантын амны цохио (зүүн урдаас)



Бунхантын амны зосон зураг (баруун урдаас)

2. Дадгын тахилын онгон, хүн чулуун хөшөөд

Сумын төвөөс баруун зүгт 24 орчим км, Цагаан хадны ам, Дадгын булгийн баруун талд, Хөдөө нуурийн зүүн талд, Магжааны хоолойн хойд талд 2 ш хүн чулуу, тахилын онгон, 23 ээл чулуутай.



Дадгын өвөлжөөний хүн чулуун хөшөөд (зүүнээс)



Дадгын өвөлжөөний хүн чулуун хөшөөд (зүүнээс)

3. Дархан уулын булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун зүгт 32 орчим км, Дархан уулын Ханангийн баруун талд олон янзын хэлбэр бүхий хүрээтэй булш, хиргисүүр бий.



Дархан уулын булш, хиргисүүр (зүүн урдаас)

4. Дунд Нарийн амны хүн чулуун хөшөөд

Сумын төвөөс баруун зүгт 26 орчим км, Хөдөө нуурийн хойд талд, Дунд нарийн амны дунд хэсэгт, Цагаан хадны баруун талд, шонгийн модны дагуу 2 ширхэг хүн чулуу, 2 тахилын онгон бий.



Дунд Нарийн амны хүн чулуун хөшөөд (урдаас)

5. Тариатын голын хиргисүүр


Сумын төвөөс баруун зүгт 34 орчим км, Тариатын голын баруун хөндийд дугуй хүрээтэй маш том хэмжээтэй хиргисүүр бий.



Тариатын голын хиргисүүр (баруун хойноос)

6. Урд хуурайн хиргисүүр, буган чулуун хөшөө

Сумын төвөөс баруун зүгт 43 орчим км-т, Урд Хуурайн ам хэмээх газар дугуй хүрээтэй нэгэн хиргисүүрийн өмнө өвөрмөц дүрслэлтэй буган чулуун хөшөө бий.



Урд хуурайн хиргисүүр, буган чулуун хөшөө, гар зураг

7. Хар усны тохойн буган чулуун хөшөө

Сумын төвөөс баруун зүгт 32 орчим км-т, Хар усны тохой гэдэг газар, Дархан уулын Ханангийн өвөрт буган чулуун хөшөө бий.



Хар усны тохойн буган чулуун хөшөө (баруун хойноос)

8. Хөшөөтийн амны тахилын онгон

Сумын төвөөс зүүн тийш 4 орчим км-т, Хөшөөтийн аманд Суман голын эрэг дээр 2 ш хөшөө чулуутай тахилын онгон бий.



Хөшөөтийн амны тахилын онгон (урдаас)

9. Хөшөөтийн булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн хойш 4 орчим км, Хөшөөтийн аманд хиргисүүр, булш нэг талбайд зэрэгцэн оршиж байна.



Хөшөөтийн амны хиргисүүр (зүүнээс)

10. Цагаан овооны булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун зүгт 45 км орчимд Цагаан овооны зүүн талд хиргисүүр булш элбэгтэй.



Цагаан овооны булш, хиргисүүр (зүүнээс)

ТӨВШРҮҮЛЭХ СУМ

Төвшрүүлэх сумыг 1938 онд Хотонт, Цэнхэр сумдаас тасдаж байгуулсан. 1954 онд татан буулгаж, Баян-Улаан, Булган сумдад нийлүүлсэн аж. Энэ нутагт Төвшрүүлэхийн САА-г байгуулхад Төвшрүүлэх сумыг дахин байгуулж харьяалуулсан. Тус сум 2012 оны байдлаар 1190 мянган га газар нутагтай, 3.2 мянган хүн амтай, 48.5 мянган толгой малтай байна. Сумын төв Таван булаг суурин нь аймгийн төвөөс төвөөс зүүн урагш 44 км зайтай оршдог.



1. Булшт толгойн булш хиргисүүр
2. Бэржингийн өвдөгийн булш, хиргисүүр
3. Майхан уулын булш, хиргисүүр
4. Модон давааны амны тахилын онгон
5. Хар хадны булш, хиргисүүр
6. Хөх сүмийн буйр

Төвшрүүлэх сум

1. Булшт толгойн булш хиргисүүр

Сумын төвөөс зүүн хойд зүгт 18 орчим км-т, Булшт толгой хэмээх газар 2 хиргисүүр, түүнээс холгүй тэгш талд мөн 1 хиргисүүр бий.



Булшт толгойн хиргисүүр (баруунаас)

2. Бэржингийн өвдөгийн булш, хиргисүүр

Сумын төвөөс хойд зүгт 15 орчим км-т, Бэржингийн өвдөг гэх тэгш талд дугуй хүрээ бүхий нэгэн хиргисүүр оршино.



Бэржингийн өвдөгийн хиргисүүр (баруун хойноос)

3. Майхан уулын булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн урагш 25 орчим км-т, бүлэг цөөн тооны дөрвөлжин булш бий.



Майхан уулын дөрвөлжин булш (баруун урдаас)

4. Модон давааны амны тахилын онгон

Сумын төвөөс зүүн урагш 18 орчим км-т, Модон давааны аманд түрэгийн үеийн хөшөө чулуутай тахилын онгон бий.



Модон давааны амны тахилын онгон (урдаас)

5. Хар хадны булш, хиргисүүр

Сумын төвөөс зүүн урд 18 орчим км-т, Хар хад гэх газар хиргисүүр булш бий. Хар хад уулын урд бэлд дугуй дараас бүхий 2 булш байна.



Хар хадны хиргисүүр (зүүн урдаас)

6. Хөх сүмийн буйр

Сумын төвөөс зүүн урд 13 орчим км-т, Эрдэнэ толгойн хаяанд Хөх сүмийн буйр хэмээх газар хэд хэдэн хиргисүүр байна. Мөн энэ газар нь нийслэл хотын түүхэнд холбогдох бөгөөд Өндөр гэгээн 1700-1719 оны хооронд нийт 19 жил суурьшиж хэд хэдэн сүм дуган барьж байсан байна.



Хөх сүмийн буйр (баруунаас)



Хөх сүмийн буйрин дээр босгосон дурсгалын хөшөө (урдаас)

ХАНГАЙ СУМ

Хангай сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Чандмань Өлзийт далайн хошуунаас салган байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 3330 мянган га газар нутагтай, 2.8 мянган хүн амтай, 80.8 мянган толгой малтай байна. Сумын төв Хунт суурин нь аймгийн төвөөс зүүн хойш 230 км зайтай оршдог.



1. Баруун эхний амны тахилын онгон, хүн чулуун хөшөө
2. Бүлээний амны тахилын онгон, хүн чулуун хөшөө
3. Давааны эхний хүн чулуун хөшөө
4. Жаргалантын дунд овооны хадны зураг
5. Мухарын амны булш, хиргисүүр
6. Ноён хангайн тахилын онгон, хүн чулуун хөшөөд
7. Оцон хадны тахилын онгон, хүн чулуун хөшөө
8. Хантрагадын хиригсүүр
9. Хавчигийн амны тахилын онгон, хүн чулуун хөшөөд
10. Цуурайн амны тахилын онгон, хүн чулуун хөшөө

1. Баруун эхний амны тахилын онгон, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун зүгт 22 орчим км, Баруун эхний аманд хүн чулуу, тахилын онгон, зэл чулуу бий. Хүн чулуу цээж хэсгээрээ хугарсан байдалтай.



Баруун эхний тахилын онгон, хүн чулуун хөшөө (зүүн урдаас)

2. Бүлээний амны тахилын онгон, хүн чулуун хөшөө


Сумын төвөөс баруун урагш 35 орчим км, Тэрхийн голын хойд эрэгт Бүлээний аманд хүн чулуу бий.



Бүлээний амны тахилын онгон, хүн чулуун хөшөө (баруун урдаас)

3. Давааны эхний хүн чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн хойд зүгт 16 орчим км, Давааны эхэн гэдэг газар түрэгийн үеийн тахилын онгон, хүн чулуун хөшөө бий.



Давааны эхний хүн чулуун хөшөө (зүүнээс)

4. Жаргалантын дунд овооны хадны зураг

Сумын төвөөс баруун урд зүгт 41 орчим км, Жаргалантын дунд өвөлжөөний баруун тийш харсан хадан дээр хадны сүг зураг бий.



Жаргалантын дунд овоо



Жаргалантын хадны зургаас

5. Мухарын амны булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун урагш 26 орчим км, Их Мухарын аманд хиргисүүр булш бий.



Мухарын амны булш, хиргисүүр (зүүн урдаас)



Мухарын амны булш, хиргисүүр


Хангай сум

6. Ноён хангайн тахилын онгон, хүн чулуун хөшөөд

Сумын төвөөс баруун урагш 6 орчим км-т, Ноён хангай уулын Овооны энгэрийн урд тахилын онгон бүхий 2 хүн чулуун хөшөө байрлана.



Ноён хангайн тахилын онгон, хүн чулуун хөшөөд (баруун урдаас)



Ноён хангайн 1-р хүн чулуун хөшөөний гар зураг



Ноён хангайн тахилын онгон, хүн чулуун хөшөөд

7. Оцон хадны тахилын онгон, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун урагш 23 орчим км-т, Оцон хадны тал хэмээх газарт хүн чулуу, 30 орчим зэл чулууд бий.



Оцон хадны тахилын онгон, хүн чулуун хөшөө (зүүн урдаас)

8. Хантрагадын хиргисүүр

Сумын төвөөс баруун урагш 35 орчим км-т, Хантрагадын аманд том хиргисүүр бий. Хиргисүүр нь дугуй хүрээтэй, чулуун овоолгын зохион байгуулалт эвдэгдээгүй байна.



Хантрагадын хиргисүүр

9. Хавчигийн амны тахилын онгон, хүн чулуун хөшөөд

Сумын төвөөс зүүн урагш 22 орчим км-т, Хавчигийн аманд 2 хүн чулуу хөшөө бий.



Хавчигийн амны хүн чулуун хөшөөд

10. Цуурайн амны тахилын онгон, хүн чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн хойш 23 орчим км-т, Нарийн гичгэнэ голын хойд, Цуурайн аманд түрэгийн үеийн хүн чулуу, тахилын онгон бий.



Цуурайн амны тахилын онгон, хүн чулуун хөшөө (зүүн урдаас)

ХАЙРХАН СУМ

Хайрхан сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Цэцэрлэг мандалын аймгийн Батцэнгэл хошуунаас салгаж байгуулжээ. Тус сум 2012 оны байдлаар 2544 мянган га газар нутагтай, 3.7 мянган хүн амтай, 188.4 мянган толгой малтай байна. Сумын төв Убулан суурин нь аймгийн төвөөс зүүн хойш 230 км зайтай оршдог.



1. Бага Өжөөгийн өвөрийн булш, хиргисүүр
2. Гол Мод-I Хүннүгийн оршуулгын газар
3. Буурлын булагийн төвд үсэгт хөшөө чулуу
4. Гунжын амны буган чулуун хөшөө
5. Дэлэн толгойн булш, хиргисүүр
6. Дээд Жарантайн хийдийн туурь
7. Нурамтын булш, хиргисүүр
8. Өндөр Улааны булш, хиргисүүр
9. Уртын шуудууны дурсгалууд
10. Хөшөөн дөрөлжийн буган чулуун хөшөө
11. Чандмань овооний шивээ
12. Шар хадны хүннү булш
13. Шивээт толгойн булш, тахилын онгон
14. Эмээл толгойн хүн чулуун хөшөө

1. Бага Өжөөгийн өвөрийн булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун урагш 16 орчим км-т, Бага Өжөөгийн өвөрт хиргисүүр булш бий.



Бага Өжөөгийн булш, хиргисүүр (урдаас)

2. Буурлын булагийн төвд үсэгт хөшөө чулуу

Сумын төвөөс урагш 27 орчим км-т, Буурлын булагийн аманд маанийн үсэгт хөшөө чулуу бий.



Буурлын булагийн төвд үсэгт хөшөө

3. Гол Мод-1 Хүннүгийн оршуулгын газар

Сумын төвөөс урагш 32 орчим км-т, Гол мод-1 хэмээх газар Хүннүгийн язгууртны булш бүхий оршуулгын бий.



Гол Мод-1 Хүннүгийн оршуулгын газар

4. Гунжийн амны буган чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн урагш 31 орчим км-т, нутагт Гунжийн аманы адагт, Гунжийн голын модон гүүрнээс баруун тийш 250 м зайд, Цагаан нуурын хөндийн баруун дэнж дээр буган чулуун хөшөө бий.



Гунжийн амны буган чулуун хөшөө (зүүн урдаас)



Гунжийн амны буган чулуун хөшөөний гар зураг



Гол Мод-1 Хүннүгийн язгууртаны оршуулгын газар

5. Дэлэн толгойн булш, хиргисүүр

Сумын төвөөс урагш 26 орчим км, Хүнүй голын баруун талд Дэлэн толгойд хиргисүүр булш бий.



Дэлэн толгойн булш (баруунаас)

6. Дээд Жарантайн хийдийн туурь

